МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,161.788... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.09.04. Даваа. №148 (4762) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +15
Шөнө +6

ЦАГ ҮЕ

Д.БЯМБАСҮРЭН: ҮНДСЭН ХУУЛИЙГ ӨӨРЧЛӨХ НЭРИЙН ДОР МОНГОЛЫН ТӨРИЙГ ТОЛГОЙГҮЙ БОЛГОХ ГЭЖ БАЙНА

IV-V нүүрт

ДЭЛХИЙ

КИМ ЗУРГАА ДАХЬ УДААГАА ЦӨМИЙН ЗЭВСЭГ ТУРШЛАА

VI нүүрт

Дугаарын 60 мөр

## Их, дээд сургуулиудыг хотоос гаргая

Ч.ЧУЛУУН

Нийслэл ачааллаа хэдийнэ даахаа больсон. Бүхий л талаар. Хүн ам өсөх нь хэрэглээгээ дагаад эдийн засгийн чадавхид сайнаар нөлөөлөх ч эсрэгээрээ эмнэлэг, сургууль, цэцэрлэг, орон сууцны хангамж гээд иргэдийн амьдралын өдөр тутмын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангах тухайд асуудал үүсдэг. Улаанбаатар социализмын үед хийгдсэн хот төлөвлөлтөөр баригдсан. Тодруулбал, орос ах нар хотын хөгжлийн. Ерөнхий төлөвлөлтөд дээр ажиллахдаа Монгол Улсын хүн ам ирэх тавин жилд үсрээд хоёр сая гаран болон тэр үед улсынх нь нийслэлд үсрээд 800 мянган хүн аж төрнө гэж тооцоолсон юм гэнэ лээ. Мөн тэр үед Улаанбаатарын хүн ам 450 мянга байсан талаар хотын музейн тайлбарлагч нэгэнтээ өгүүлж байсансан. Гэтэл өнөөдөр хотын үндсэн хүн ам хэд болоод байгаа билээ. Өнгөрсөн 2016 оны нэгдүгээр сарын нэгний байдлаар Улаанбаатар хотын хүн ам 1,345,500 гэж статистик мэдээлэлд дурдагджээ.

**Үргэлжлэл нь III нүүрт**

# Засгийн газар “ХОРХОЙТОЙ ШҮД”-ээ сугалах уу




Н.ПУНЦАГБОЛД

МАН-ын 65 гишүүний тал нь Засгийн газраа огцруулах бичигт гарын үсэг зурж, УИХ-д өргөн барьчихаад байгаа. Тэр дагуу УИХ-ын дарга ээлжит бус чуулган зарласан. Энэ долоо хоногтоо багтаад ээлжит бус чуулган хуралдаж, Засгийн газрын асуудлыг шийднэ. Хамгийн оройтлоо гэхэд лхагва гарагт хуралдчих болов уу гэж хараад байна. Харин ээлжит бус чуулганаар Засгийн газар унах уу, тогтож үлдэх үү гэдэг л сонин байгаа юм. Өнгөрсөн долоо хоногийн лхагва гарагт Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж, Засгийн газрыг унагах шаардлагагүй гэсэн шийдвэр гаргасан. 17 гишүүний олонх нь Ерөнхий сайдыг суудалд нь үлдээхээр шийдчихээд байгаа. Түүнээс хойш 5, 6 хоногийн хугацаанд хагаралдаад байгаа хоёр тал нэлээд ярилцаж, зөвшилцсөн нь тодорхой.

**Үргэлжлэл нь III нүүрт**

**АЖИЛД АВНА**

**Гэрэл зурагчин** /зургийн аппараттай бол давуу тал болно/

**эх бэлтгэгч** /Indesign, Photoshop/

**сэтгүүлч** /2017 онд их, дээд сургууль төгссөн байж болно/

**Утас: 99189158**

PRODUCTION art

Ражив Гандийн Нэрэмжит
ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ



## МЭНДЧИЛГЭЭ

Эрдэмтэн багш, оюутан сурагчид, ажилтан ажиллагсад, төрөлх сургуультай маань амьдрал хувь заяагаараа холбогдсон ахмадууд та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.
Монгол Улсын мэргэжлийн боловсролын ууган сургуулиудын нэг Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж нь 51 дэх жилээ мэргэжлийн боловсролын салбарын сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлэх түүхэн шинэ хуудсыг нээж байгаадаа баяртай байна.
Өнгөрсөн хугацаанд манай сургууль хөгжлийн үе шат бүхэнд мэргэжлийн чиг баримжаа шинэчлэгдэн, үйлдвэрлэл, нийтлэг үйлчилгээ, дурслэх урлаг, техник технологийн салбарт бүх шатны мэргэжилтэй боловсон хүчнийг мэргэжлийн, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын үе шаттай боловсрол олгон бэлтгэдэг “Сургалт-үйлдвэрлэл-эрдэм шинжилгээний байгууллага” болтлоо хөгжин дэвжиж ирсэн билээ. ҮУПК нь чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтын үйл ажиллагаа хэвийн явуулж ирсэн бөгөөд "Мэргэжилээ зөв сонгосон мэргэжилдээ үнэнч ур чадвартай байх амьдралын баталгаа юм" эрхэм зорилготой хичээл сургалтын үйл ажиллагаа хэвийн явуулж хичээл дадлагын ажлыг ОХУ, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ажил мэргэжлийн сургууль БНСУ- д нийт 70 гаруй оюутан суралцагсдыг дадлага хийлгэсэн амжилтаар энэ хичээлийн жилийг угтлаа. Манай хамт олон 2017-2018 оны хичээлийн жилд өнгөрсөн онд хийж хэрэгжүүлсэн амжилтуудаа бататган хүн бүр эрхэлсэн ажил мэргэжилдээ эзэн нь болж хувийн ёс зүй хариуцлагыг эрхэмлэж, Мэргэжилдээ үнэнч ур чадвартай, сэтгэлтэй зөв төлөвшсөн иргэнийг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх эрхэм зорилттой шинэ хичээлийн жил эхлүүлж байгаадаа баяртай байна. Мэргэжлийн боловсролын салбарын чиг хандлагыг тодорхойлогч эвсэг, оюунлаг, мэргэжлийн өндөр ур чадвартай эрдэмтэн багш, ажилтан ажиллагсадтай ажиллаж байгаадаа бид бахархалтай байдаг юм. Мэргэжлийн боловсролын салбарт нэр төрөө дуурсгаж, энэ салбарын хөгжлийн төлөө хувь заяагаараа холбогдон мөр зэрэгцэн зүтгэж яваа эрдэмтэн багш нар, ахмад үе ажилтан албан хаагчид, нийт оюутан залуустаа хичээлийн шинэ жилийн баярын мэнд хүргэе
Сайн үйлс дэлгэрэх болтугай.

Ражив Гандийн Нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн

ЗАХИРАЛ Б.ДАВААЖАВ

| | ХААН банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2428.00 | 2444.00 | ФУНТ | 3078.00 | 3158.00 |
| ЕВРО | 2841.00 | 2909.00 | РУБЛЬ | 39.80 | 42.60 |
| ИЕН | 21.95 | 22.53 | ЮАНЬ | 364.00 | 367.50 |

| | Худалдаа хөгжлийн банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2425.00 | 2439.00 | ФУНТ | 3086.00 | 3205.00 |
| ЕВРО | 2849.00 | 2948.00 | РУБЛЬ | 40.40 | 44.11 |
| ИЕН | 21.60 | 22.56 | ЮАНЬ | 367.00 | 371.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

БАЙР СУУРЬ



## Ө.ЛУВСАНРЕНЧИН: Сонгуулиар иргэд, сонгогчдын өмнө уран донгодчихоод сонгогдсоныхоо дараа тэдний итгэл рүү ус цацаж болохгүй

С.МӨНХ

*“Монгол Ардын Намын гишүүд дэмжигчдийн холбоо”-ны ерөнхий зохицуулагч Ө.Лувсанренчинтэй ярилцлаа.*

**-“Монгол Ардын Намын гишүүд дэмжигчдийн холбоо”-ноос нэр бүхий хүмүүст ил захидлыг хэвлэл мэдээллээр дамжуулан хүргэсэн. Ямар учиртай ил захидал илгээв ээ?**

-ӨнгөрөгчУИХ-ынсонгуулиар ард иргэд МАН-д их итгэл хүлээлгэж, 65 суудалтай илт давуу ялалтыг өгсөн. Сонгогч түмний буянаар олонхи болсон МАН-ын Засгийн газар богино хугацаанд танхимаа бүрдүүлж ажиллаад нэг жилийн нүүр үзэх гэж байна. Харамсалтай нь МАН-ын гишүүд, дэмжигч, иргэд сонгогчдын ачаар УИХ-д суусан 65 гишүүний 30 нь өнөөдөр Засгийн газраа огцруулах бичигт гарын үсэг зурж, есхөн хүнтэй АН-ын тоглолтын тойрогт ороод явж байгаа нь байж болохгүй үзэгдэл. Үндсэндээ МАН-ын гал тогоонд өрнөж байгаа улс төрийн гал дээр АН тос асгасан зүйл болж байна. МАН хэзээнээсээ л төр, ард түмэнтэй холбоотой асуудлыг төрийн ордонд, намынхаа асуудлыг Тусгаар тогтнолын ордондоо шийдэж ирсэн нам. Харин өнөөдрийн улстөрийн нөхцөл байдлыг харвал манай нам дотор үүссэн зөрчил тогооноосоо хальж, төрийн ордонд өрнөж байгаа нь байж болохгүй зүйл. Намын дотоод асуудлыг намдаа ярьдаг, төрийн ажлыг ордондоо ярьдаг байя л гэсэн үндсэн шаардлагыг ил захидалдаа дурьдсан. Ер нь төр барьж байсан ямар ч нам Засгийн газраа унагалаа гээд ард түмнээсээ сайн үнэлгээ авдаггүй. Харин ч улам дорддог, ялагдлын үндсэн шалтгаан нь болдог л доо. Энэ бүхнийг МАН-ын гишүүд, дэмжигч, сонгогчдын ачаар УИХ-д суусан 65 гишүүндээ болон намын удирдлагуудад ил захидлаараа дамжуулан сануулсан байгаа.

**-Танай нам доторхи зөрчил тогооноосоо хальж, төрийн ордонд үйл явдал өрнөж байгаа нь зохимжгүй гэж та хэллээ. МАН-ын хагарлын гол шалтгааныг юу гэж харж байна вэ?**

-Хагарлын гол шалтгаан нь нөгөө л улиг болсон “60 тэрбум”-ын бичлэгтэй холбоотой гэдгийг өнөөдөр хүн бүхэн мэдэж байгаа. Алдарт

> ...УИХ-д МАН-ыг төлөөлж суугаа 65 гишүүн өөрийн хүчээр, эр бяраар УИХ-ын сонгуульд ялчихсан юм шиг оодорч, тодорч яваа нь өнөөдөр нууц биш. Би тэдэнд хандаж ганцхан юм хэлье! Уучлаарай, та нар МАН-ын мянга мянган гишүүд, дэмжигчдийн итгэл, сэтгэл, зүтгэлээр УИХ-д сонгогдсон гэдгээ битгий март...

“60 тэрбум”-ын бичлэгийг Ерөнхий сайд, Засгийн газарт нааж боргоод байгааг нуулгүй хэлэхэд гайхаж л байна. Учир нь “60 тэрбум”-ын бичлэг бол нийслэлийн МАН-ын хорооны удирдлагуудын асуудал. Энэ бичлэгийн үнэн, мөнийг тогтоодог байгууллагууд нь тогтоох байх. Дээрээс нь саяхан болж өнгөрсөн Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн нөлөөлж байна. Ерөнхийлөгчийн сонгуулийн ялагдлын хариуцлагыг бас л Засгийн газартай нааж яриад байгаа нь буруу л даа. Монгол Улс парламентын засаглалтай болохоос Ерөнхийлөгчийн засаглалтай орон биш. Хоёрдугаарт, парламентад олонхи болсон нам Засгийн газраа байгуулж ажилладаг. Үнэхээр сонгуулийн ялагдлын хариуцлага ярих гээд байгаа бол намын Бага, Их хурлаараа ярилцаад шийдэх ёстой асуудал. Гэтэл эрх ашгийн эрэмбэ дараагаа умартсан манай намын зарим гишүүд шууд л “Засгийн газрыг огцруулах ёстой. Тэгж байж МАН шинэчлэгдэнэ” гэж яриад байгаа нь зөрчлийг улам даамжруулж байна. Засгийн газар огцорлоо гэж бодоход хамгийн их хохирох хүмүүс нь монголын ард түмэн шүү дээ. Улстөрийн тогтвортой байдлыг бий болгоорой гэж 65-ууланг нь сонгосон болохоос дээр очоод бужигнуулаарай гэж сонгоогүй гэдгийг тэд ухамсарлах ёстой.

**-Сонгуулийн дараа намын удирдлагуудад хариуцлага тооцох асуудал яригдсан ч өнөөдрийг хүртэл намын Бага, Их хурал хуралдаагүй байна. Энэ нь дээрх 30 гишүүний эгдүүцлийг хүргэсэн гэж ойлгоод байгаа?**

-Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа МАН-ын Удирдах зөвлөл хуралдсан. Ингэхдээ сонгуульд амжилтгүй оролцсон талаар дүгнэлт хийх шийдвэрийг гаргасан. Энэхүү дүгнэлтийг хэдхэн өдрийн дотор хийчихдэг юм биш. Мэдээж хугацаа шаардагдана. Удахгүй болох Бага хурлаараа яагаад ялагдсан талаар дүгнэлт гарах байх. Мөн Засгийн газрыг огцруулах бичигт гарын зурсан зарим нэг гишүүн Ерөнхийлөгчийн сонгуулийн төв штабад ажлын хэсэг ахалж ажилласнаа мартаад байх шиг байна. 2016 оны УИХ-ын сонгуульд дэвшүүлсэн манай намын мөрийн хөтөлбөрт “Улстөрийн тогтвортойбайдлыгбийболгож, эдийн засгийн хямралыг даван туулна” гэсэн заалт бий. Намаасаа дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн эсрэг явж байгаа гишүүдийг ойлгохгүй байна л даа. УИХ-ын сонгуулиар ард түмэн 65 хүнийг биш МАН-ын мөрийн хөтөлбөрийг сонгосон гэдгийг тэд өнөөдөр мартсан байна. Ингэж хоёр нүүр гаргаж болохгүй. Сонгуулиар иргэд, сонгогчдын өмнө сайхан уран донгодчихоод сонгогдсоныхоо дараа тэдний итгэл рүү ус цацаж болохгүй биз дээ. Эргээд уулзахгүй нүүр биш. 2020 оны УИХ-ын сонгуульд тэд дахиад л ард түмнээсээ “Намайг сонгоочээ” гээд гуйна. Тухайн үед нь иргэд сонгогчид аль хэдийнэ дүнгээ тавьчихсан байна.

**-Ямар дүн тавих бол...?**

-Мэдээж энэ байдлаараа үргэлжилбэл маш муу дүн тавина. Одоо байгаа 65-аас бүлэг байгуулах хэмжээний хүн үлдэх үү, үгүй юу гэдэг асуудал яригдана. Хамгийн муу хувилбараар нь жишээ авч үзье. Ж.Эрдэнэбатын Засгийн газрыг унагалаа гэж бодъё. Шинээр Засгийн газар байгуулагдаад хэр удаан оршин тогтнох вэ? Хамгийн ихдээ л 12 сар болно. Дахиад л унана. Үндсэндээ нэг удаагийн сонгуулийн циклд гурван Засгийн газрын нүүр үзнэ гэсэн үг. Ийм тогтворгүй байдлыг хэнч хүсэхгүй нь ойлгомжтой. Үр дүнд нь засгаа унагаж тоглосон МАН ялагдана. Хамгийн том хохирогч нь ард түмэн болж хоцорно. Тогтворгүй байдлын сургаар гадны хөрөнгө оруулагчид хүлээлтийн байдалд шилжчихлээ. Дөнгөж он гарангуут Монгол Улс Н.Алтанхуягийн алдарт “Чингис” бондын 500 сая ам.долларын төлөлт хийнэ. 500 сая ам.долларын төлөлтийг хийж чадахгүй бол манай улс олон улсад дампуурлаа зарлана. Энэ бүхний хариуцлагыг хэн хүлээх вэ? Нам, намын гишүүд, дэмжчигчдээ хоёр хувааж тоглосон нөхдүүд хариуцлага хүлээх үү? Үгүй л байхгүй юу. Тэдэнд хариуцлага хүлээх ухамсар, ёс зүй байдаггүй л байхгүй юу. Нам ялагдсан үед нь хаяж явчихаад, ялсан үед нь тодроод гараад ирдэг нөхдүүд манай намд цөөнгүй бий.

**-“Монгол Ардын Намын гишүүд, дэмжигчдийн холбоо” цаашид ямар арга хэмжээ явуулах төлөвлөгөөтэй байна вэ?**

-УИХ-д МАН-ыг төлөөлж суугаа 65 гишүүн өөрийн хүчээр, эр бяраар УИХ-ын сонгуульд ялчихсан юм шиг оодорч, тодорч яваа нь өнөөдөр нууц биш. Би тэдэнд хандаж ганцхан юм хэлье! Уучлаарай, та нар МАН-ын мянга мянган гишүүд, дэмжигчдийн итгэл, сэтгэл, зүтгэлээр УИХ-д сонгогдсон гэдгээ битгий март. Мөн МАН-ын үнэт зүйл, ганхашгүй багана болсон эрх ашгийн эрэмбэ дараагаа бүү умарт. Хувийн эрх ашгийн төлөө, сандал суудлын төлөө намын дотоод хагарлыг улам хурцатгавал манай холбоо ч зүгээр суухгүй. УИХ дахь МАН-ы бүлгийн 65 гишүүн, намын удирдлагад эв нэгдлийг хангаж ажиллах шаардах бичиг хүргүүлнэ. Шаардах бичгийг хэрэгжүүлэхгүй бол тэмцлийн хурц хэлбэрт шилжинэ.

**-Танай холбоо анх хэдэн онд үүсэн байгуулагдаж байсан тухай товчхон танилцуулаач?**

-“Монгол Ардын Намын гишүүд, дэмжигчдийн холбоо” анх 2011 онд байгуулагдаж байсан. Өнөөдрийг хүртэл тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж ирсэн холбоо. Мөн үйл ажиллагаагаа өргөжүүлж Монгол Улсын 21 аймгийн 15-д нь салбар холбоогоо байгуулчихаад байна.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаарх хэлэлцүүлэг боллоо



Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг 21 аймаг, нийслэлийн есөн дүүргийн иргэдэд танилцуулга хийн, хэлэлцүүлж байгаа билээ. Энэ хүрээнд УИХ-ын Тамгын газраас Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг энэ сарын 1-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа агентлагуудын албан хаагчдын дунд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт УИХ-ын Тамгын газар, ХЗДХЯ-ны холбогдох албан тушаалтнууд оролцсон юм. УИХ-ын Тамгын газрын мэргэжилтнүүд төслийн талаарх танилцуулга хийсний дараа хэлэлцүүлэгт оролцогчид тодруулж асуулт асуусан. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаарх хэлэлцүүлгийг нийт улс орон даяар хэлэлцүүлэх ажил өндөрлөж байгаа юм. Энэ өдрүүдэд яам, агентлаг, УИХ-ын харьяа байгууллагууд чиглэл чиглэлээрээ төслийг хэлэлцэж байгаа бол хууль зүй, улс төр судлаач мэргэжилтнүүд, эрдэм шинжилгээний байгууллагууд нарийвчилсан хэлэлцүүлгийг явуулж байна. Түүнчлэн улс төрийн намууд төсөлтэй холбоотой санал, дүгнэлтээ бэлтгэн ажиллаж байгаа аж. Есдүгээр сарын сүүлээр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар эрдэм шинжилгээний хурал болж, судлаач, шинжээчид төсөлтэй холбоотой дүгнэлтээ танилцуулна. Улс орон даяар явагдсан хэлэлцүүлгийн дунд өнөөдрийн байдлаар 10 мянга гаруй иргэн саналаа бичгээр ирүүлээд байгаа бөгөөд эдгээрийг нэгтгэх ажлыг УИХ-ын Тамгын газар хийж байгаа аж.

## ОХУ-д үйлдвэрлэсэн техник, тоног төхөөрөмжийг ургац хураалтын өмнө тариаланчдад хүргэлээ

Б.СУМЪЯА

ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн ОХУ-д айлчлах үеэрээ Хөдөө аж ахуйн сайд А.Н.Ткачев, орлогч сайд Е.В.Громыко нартай уулзалт хийж, уулзалтын үр дүнд ОХУ-д үйлдвэрлэсэн 10 сая ам.долларын өртөг бүхий хөдөө аж ахуйн зориулалттай техник, тоног төхөөрөмжийг 3-5 жилийн хугацаатай эргэн төлөх нөхцөлтэйгөөр авахаар тохиролцсон. “Атрын III аян”-ыг үргэлжлүүлэх ажлын хүрээнд хийгдэж буй энэхүү ажил өнөөдөр бодит биелэлээ олж ургац хураалтын өмнө тариаланчдын гарт шинэ техник тоног төхөөрөмжүүд очиж байна. Газар тариалангийн техник тоног төхөөрөмжийг гардуулан өгөх үйл ажиллагаа Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Хөтөл хотод өнгөрсөн сарын 31-нд боллоо. Тус үйл ажиллагаанд ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн, Монгол Улсын Ерөнхий сайд асан Ш.Гунгаадорж, УИХ-ын гишүүн Н.Оюундарь, Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил болон бусад албаны хүмүүс, тариаланчид оролцов. Үйл ажиллагааг нээж ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн “Монгол Улсын Засгийн газрын тогтоол гарч “Атрын III аян”-г үргэлжлүүлэх шийдвэр гарсан. Энэ хүрээнд тариалан эрхлэгчдийн техникийн шинэчлэл хийх төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Яг нэг жилийн өмнө ОХУ-д айлчлах үеэрээ техник тоног төхөөрөмж авах талаар ХАА-н сайдтай уулзаж, хүсэлт тавьсны үр дүнд маш богино хугацаанд ургац хураалтын өмнө өндөр хүчин чадалтай, хямд үнэтэй техник тоног төхөөрөмж тариаланчдын гарч очиж байгаад сэтгэлд өндөр байна. Техникийн шинэчлэл гэдэг газар тариалангийн салбарт маш чухал. Сүүлийн 10 гаруй жил хийгдээгүй техникийн шинэчлэлийг өнөөдөр хийж байна. Ургацаа хураах, хадлан тэжээлээ бэлтгэж байгаа энэ үед шинэ, хүчин чадал өндөртэй техник тоног төхөөрөмж ашиглах нь чухал юм” хэмээв. ОХУ-аас үр тарианы комбайн, өвс хамагч боогч, тармуур, ангилсан тариа хаман, хураагч, жатганы чиргүүл, будаа ачигч, трактор, будаа сортлогч, будаа цэвэрлэгч, хор цацагч, хор цацагч өөрөө явагч, сийрүүлүүр, үрлүүр хоёр давхар хадуур зэрэг техник тоног төхөөрөмж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд асан Ш.Гунгаадорж “Өнөөдөр газар тариалангийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжийн иж бүрдлийг хараад маш их баярлаж байна. Атрын III аяныг туулсан, хөдөө аж ахуй газар тариалангийн салбарт насаараа зүтгэсэн хүний хувьд техникийн шинэчлэл хийнэ гэдэг ямар их чухал гэдгийг мэднэ. Сүүлийн хэдэн жилд техникийн шинэчлэл хийгдээгүй явсаар шинэ Засгийн газрын үед техникийн шинэчлэл иж бүрнээрээ хийгдэж бодит ажил болж байгааг хараад сэтгэл өндөр байна. Үүнд Монгол Улсын Засгийн газар, ХХААХҮЯ, П.Сэргэлэн сайдад Атарчин хүний хувьд баярласнаа дахин хэлмээр байна. П.Сэргэлэн сайдын хувьд ОХУ-руу олон удаа явж тохиролцсоны үр дүнд сүүлийн үеийн шинэ техник тоног төхөөрөмж нийлүүлэгдэж байна. Энэ бол эхлэл” гэв.

Мөн ОХУ-д үйлдвэрлэсэн техник тоног төхөөрөмж авч байгаа тариалан эрхлэгчдэд цаг хугацаа, хөрөнгө хэмнэсэн, тэдний ажлыг улам хөнгөвчилсөн бодит ажил болж байна гэдгийг энэ үеэр онцолж байсан юм.

## ҮЗЭЛ БОДОЛ

# ЗАСГИЙН ГАЗАР "ХОРХОЙТОЙ ШҮД"-ЭЭ СУГАЛАХ УУ

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Тиймдээ ч Засгийн газар огцрохгүй тал руугаа хэлбийж байгаа талаар эх сурвалжууд мэдээлж байна. Засгаараа тоглохын оронд "хорхойтой шүд" сугалах ажиллагаа руу шилжиж байгаа бололтой. Ямар ч байсан энэ удаадаа тэсэж үлдэх бүхий л аргыг хэрэглэж байна гэж дүгнэж болох байх. Засгийн газрыг огцруулах олон шалтгааны нэг нь 60 тэрбумтай холбоотой асуудал. Тэгвэл энэ мэт асуудалд орооцолдсон НИТХ-ын дарга Ц.Сандуй өөрийн хүсэлтээр огцрох өргөдлөө өгчихлөө. МАН, тэр дундаа намын дарга нэр хүндээ аварч үлдэхийн тулд түүнийг золигт гаргаж байгаа нь байх. Дээрээс нь Засгийн газрыг авч үлдэхийн тулд ийм алхам хийсэн гэж ойлгож ч болохоор байна. Ямар ч байсан эхний ээлжинд нэг хүн өргөдлөө өгч, албан тушаалаасаа буулаа. Ингэснээр Засгийн газрыг унагах олон шалтгааны нэг нь алга болж байна гэсэн үг. Цаашлаад Засгийн газар "хорхойтой шүднүүд"-ээ суга татчихвал өвдөлт намдана. Харин чухам хэнийг сугалах гээд байгаа нь сонирхолтой байна. Зарим эх сурвалжийн мэдээлж байгаагаар 4-5 сайд "шүд сугалах" ажиллагаанд өртөж, зөөлөн суудлаасаа ховхрох нь ээ. Юун түрүүнд Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг "хорхойтой шүд"-ний тоонд орж, ажлаа өгөх сураг дуулдаж байна. Угаасаа Шадар сайд У.Хүрэлсүх "шүд сугалах" тохироог хийж байгаа бол хамгийн түрүүнд түүнийг суга татах нь ойлгомжтой. Дээрээс нь өнөөдрийг хүртэл жил гаруйн хугацаанд Засгийн газрын сайдуудаас хамгийн муу ажилласан нь А.Цогцэцэг гэж хэлэхэд нэг их буруутаад байх юмгүй. Эрхэм сайдтан сүүлийн үед гадаад руу томилолтоор явж, хурал семинарт сууж, "сэм найрлах"-аас өөрөөр харагдахгүй л байгаа шүү дээ. Түүний араас Засгийн газрын нэр хүндийг хамгийн их унагаж байгаа салбар болох Батлан хамгаалахын сайдыг сугалах сураг дуулдаж байна. Ерөөс Б.Бат-Эрдэнэ сайдыг ажлаа авснаас хойш энэ салбарт олон ч хэрэг гарч, цөөнгүй албан хаагчид амиа алдлаа. Тэр дундаа 2017 он гарсаар эх орноо хамгаалах гэж эр цэргийн



...Салбараа сайн удирдаж чадаагүй, Засгийн газрын нэр хүндийг унагаж байгаа гэх мэт янз бүрийн шалтгаанаар л сайдуудыг сугалах нь тодорхой. Нөгөө талдаа МАН-ын даргын хүмүүсээс заримыг нь эргүүлж татаж, оронд нь Шадар сайдын талаас хүн оруулж ч магадгүй юм...

албанд мордсон залуучууд энх цагт хэчнээнээрээ ч амь насаа алдав даа. Энэ бүхэнд шууд салбарын сайдыг буруутгах бас хэцүү. Гэхдээ жилийн хугацаанд энэ хүн салбартаа олигтой ажил хийгээгүйн бас нэг үр дүн нь энэ. Боловсролын сайдыг шалгалтын материал задарсны төлөө огцруулж, сольж болж байхад алба хаагчдын амь хэд хэдээрээ эрсдээд байхад яагаад Батлан хамгаалахын сайдыг "халж" болохгүй гэж. Тийм биз дээ. Мөн Зам тээвэр, хөгжлийн сайд Д.Ганбатын нэр ч яригдаж байгаа юм билээ. Түүнээс гадна Барилга, хот байгуулалтын сайдыг "шүд сугалах" ажиллагаанд өртөж болзошгүй байгаа талаар эх сурвалжууд мэдээлж байгаа юм. Салбараа сайн удирдаж чадаагүй, Засгийн газрын нэр хүндийг унагаж байгаа гэх мэт янз бүрийн шалтгаанаар л сайдуудыг сугалах нь тодорхой. Нөгөө талдаа МАН-ын даргын хүмүүсээс заримыг нь эргүүлж татаж, оронд нь Шадар сайдын талаас хүн оруулж ч магадгүй юм. Гэхдээ эцсийн байдлаар яг хэн "хорхойтой шүд"-ний тоонд орох нь бас сонин л доо. Эцсийн дүндээ Засгийн газар унахгүй үлдэж байвал ард иргэдэд хэрэгтэй. Монгол Улсад ч хэрэгтэй биз дээ. Жилийн хугацаанд гарсан эдийн засгийн өөрчлөлт, тоон үзүүлэлтийг харвал энэ Засгийн газар, Ерөнхий сайд тийм ч муу ажиллаагүй. Харин танхимын гишүүд нь жаахан тааруу, муу сурлагатанууд цөөнгүй байгаа гэдэг нь үнэн. Тийм болохоор "хорхойтой шүд" сугалах тохироо хийгээд, энэ удаадаа Засгаа аварч үлдэх нь дээр. Ерөнхий сайдын тэгж зүтгэж байгаа нь ч зөв. Гэхдээ энэ бүхэн ердөө л урьдчилсан таамаг. Эх сурвалжууд мэдээлэл өгч байгаа хэдий ч ээлжит бус чуулган дээр юу болохыг хэн мэдлээ. Ерөнхий сайд бол арваннэгдүгээр сар хүртэл ямар нэг байдлаар тэсэж үлдэхийн төлөө тэмцэж байгаа сурагтай. Хэрвээ тэр хүртэл тэсэж чадвал дараагийн сонгууль болтол элдэв асуудал бага гарах байх. Энэ жилийн тухайд бол Засгийн газар ганхах олон шалтгаан байна. Одоо үүсээд байгаа нөхцөл байдал "шүд" сугалаад намдлаа гэж бодъё. Ээлжит бус чуулганаар ямар ч үр дүн гарсан байсан дараа нь МАН-ын Бага хурал хуралдана. Ерөнхийдөө есдүгээр сарын дундуур хуралдах товтой байгаа. Бага хурлаар намын даргад хариуцлага тооцох асуудал яригдах байх. Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор. Тийм болохоор М.Энхболд дарга ажлаа өгөх боловуу. Харин түүний оронд хэн намын дарга болохоос шалтгаалаад Засгийн газар огцрох эсэх асуудал ч яригдана. Хэрвээ Ерөнхий сайд намын даргын албаа авчихвал Засгийн газарт аюулгүй. Шадар сайд У.Хүрэлсүх болон өөр хүн намын дарга болбол Ерөнхий сайдаа хийнэ гэж бужигнуулах магадлал ч бас байгаа юм. Тийм болохоор л Ерөнхий сайд Э.Эрдэнэбат арваннэгдүгээр сар хүртэл тэсэх гээд шүд зуугаад байна. Энэ удаадаа бол "шүд" сугалах нь тодорхой болчих шиг боллоо. Зарим нэг хүн өргөдлөө өгсөн нь энэ таамгийг улам лавшруулж байгаа юм шүү дээ.

# Мөнгө харсан томилгоо, мэдлэггүй боловсон хүчнээс татгалзах болжээ

Улс төрийн ууган хүчин МАН дотроо бужигнаантай байна. Засгийн газрын хувь заяа дээсэн дөрөөн дээр дэнжигнэхтэй зэрэгцэн НИТХ-ын дарга Ц.Сандуй ажлаа өгөхөөр болж өргөдлөө өглөө. Түүний хувьд 60 тэрбумын бичлэг огцрох гол үндэслэл нь болсон бол араас нь Нийслэлийн Засаг дарга огцорч мэдэхээр улс төрийн нөхцөл байдал үүсчээ. Түүнийг хурдтай ажиллаж, гаргасан шийдвэрүүддээ хариуцлага хүлээж чадахгүй дахин дахин эргэж буцаж байна хэмээн иргэд дургүйцэж бухимдлаа илэрхийлэх болсоор удсан. Хамгийн сүүлд хот төлөвлөлт, дэд бүтэц эхнээсээ буруу хийгдсэн гэж дүгнэгддэг хотод автомашины зүүн гар тийш эргэх хөдөлгөөнийг хориглосон шийдвэр гаргасан нь түгжрэлийг нэмсэн үү гэхээс хассангүй. Дээрээс нь орлогч нь түүнийг байхгүй үед энэ шийдвэрийг гаргасан гэсэн нь түүнийг ажлаа мэдэхгүй нэгэн болгон харагдуулж, улс төрийн нөхцөл байдал хурцадсан үед С.Батболдыг шүүмжлэх галыг өрдөж, дайран дээр нь давс нэмж орхив. Засаг дарга огцрох юм бол нийслэлийн агентлаг газруудын дарга нар хөдлөх нь дамжиггүй. Хөдөлгөөнд орж солигдох дарга нарын оронд хэн томилогдож, ирэх сонгуулиас өмнө иргэдийн сэтгэлд хүрэхүйц ямар ажил хийх вэ гэдэг л илүү чухал болоод байна. Тиймээс ч МАН-ын жирийн гишүүд үүнд аль хэдийн анхаарал хандуулаад эхэлсэн. Халаа сэлгээ хийхийг ч дэмжиж байгаа аж.

Ц.Сундуйн хувьд намын анхан шатны гишүүдийн дэмжлэгийг авч чадахгүй шахам байсаар уджээ. Тиймээс ч анхан шатнаасаа эхлээд дунд дээд шатандаа түүнийг огцруулахыг дэмжигсэд олон байсан. Түүнийг анх томилогдоход намын анхан шатны гишүүд нь дээд дарга нар яаруу бачуу хүнээ сайн судлалгүй томиллоо гэх шүүмжлэлийг хөврүүлж байжээ. Тиймээс ч энэ алдааг одоо дахин давтахуйн тулд цаашид томилогдох хүмүүсийг ажлын дадлага туршлагатай, намын нийт гишүүдийн дэмжлэгийг авч чадахуйц, олон нийтэд танигдсан, мэдлэг боловсролтой, шийдэмгий, ёс зүйтэй, нам дамжсан олигархи бүлэглэлтэй холбоогүй, чадварлаг мэдрэмжтэй хүн байх хэрэгтэй гэж намын жирийн гишүүд нь зөвлөж байгаа. Мөн намын анхан шатны гишүүдийн санал бодлыг дарга нар илүү сонсох хэрэгтэй. Дээрээс доош биш доороос дээш өгссөн шийдвэр гаргаж байж амьдралд илүү ойртон, ард иргэдэд хүрсэн ажил нь хийдэг болно гэж зөвлөж байгаа юм.

Яаж ч бодсон МАН хүнээ сайн таньж, албан тушаалын томилгоог зөв хийж, иргэддээ чиглэсэн ажил хийхгүй бол ирэх сонгуульд ялах магадлал бага. Мөнгө харсан томилгоо хийж, ажил мэдэхгүй хүмүүст албан тушаал өгсөн нь намын нэр хүндийг унагаж иргэд олон түмний дэмжлэгийг зогсоосныг




Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн харууллаа гэж гишүүд нь дүгнэх болсон. Тиймээс ч нам шинэчлэгдэж, мэдлэг, чадвартай боловсон хүчнийг сонгох нь улс орны өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, намын нэр хүндийг өсгөх ганц боломж гэж дүгнэж байна. Ямартаа ч МАН-ын энэ удаагийн халаа сэлгээний үеэр хаана хэн томилогдож, юу хийж чадахыг олон нийт харах л үлдлээ.

Дугаарын **60** мөр

## Их, дээд сургуулиудыг хотоос гаргая

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Мэдээж эл тоон үзүүлэлтийн 30 гаруй хувийг оюутан сурагчид эзэлж буй. Эднийг явуулын хэмээн нэрлэж болох ч зуны хоёр сард л хотын гадна амьдарч бусад цагт үндсэн хүн амын адил бүхий л үйлчилгээг авдаг. Өглөө, оройдоо нийтийн тээврээр зорчиж, өвдаж хавдвал харьяа газрынхаа өрхийн эмнэлгээр үйлчлүүлэх эрх нь тэдэнд нээлттэй. Заримдаа маниасаа илүү хөнгөлтийг эдэлдэг. Гэвч бүх зүйлд хэмжээ хязгаар гэж бий. Адгуустай зүйрлэвэл нуруугаа авсан морь лугаа адил болоод байгаа. Тиймээс хүн амын нягтаршлыг сааруулах бодлогыг нийслэлийн удирдлагууд хэрэгжүүлэх цаг болжээ. Үүний нэг хэлбэр нь их, дээд сургуулийг хотоос гаргах явдал. Өнөөдөр Улаанбаатар хотод төрийн болоод хувийн хэвшлийн 96 их, дээд сургууль, коллежид 150 мянга орчим охид, хөвгүүд суралцаж байна гэхээр тэр хэрээ нийслэлийн ачаалал нэмэгдэж таарна. Энэ нь эдийн засгийн хувьд асар өндөр зардал шаардагдах хэдий ч улс орны эрх ашгийн тулд цаг алдалгүй авах л ёстой арга хэмжээнүүдийн нэг юм. Нөгөөтэйгүүр, манай төрийн өмчит их, дээд сургуулиудын хичээлийн байруудын ашиглалтын хугацаа ерөнхийдөө дуусч буй. Сургуулийн хамт олон ч үйл ажиллагаагаа өргөжүүлж, дэлхийн жишигт хүрье гэж тэмүүлэвч шинэ барилга байшин барих газар нь олдохгүй болсон. Төр үүнийг нь далимдуулаад их, дээд сургуулиудыг хотоос гаргах саналыг салбарынх нь яамаар дамжуулаад тэдэнд тавих ёстой санагдана. Дэлхийн жишиг ч ийм. Ойрын жишээ авахад, Бээжин хот төвдөө нэг ч дээд сургуульгүй. Оюутны хотхон хийгээд их, дээд сургуулиуд нь хотынхоо баруун, зүүн жигүүрт байрласан байдгийг хэн хүнгүй мэдэх байх. Орос ч ялгаагүй. Энүүхэн Эрхүү хот ч ялгаагүй. Эрхүүгийн ХААИС гэхэд хотын баруун хойд захад оршдог. Их, дээд сургуулиа дагаад багш, ажилчдын байр, үйлчилгээний байгууллагууд нь сургуулиа дагаад бий болдог. Тэр хэрээр ажлын байр шинээр бий болно. Учир иим тул өөрсдийнхөө санал санаачилгаар хотын гадна хичээлийнхээ байрыг шинээр барьж байгаа болох барихаар төлөвлөж буй их, дээд сургуулиудыг төр бодлогоор дэмжиж өгөх хэрэгтэй болов уу. Манай зарим их сургууль тухайлбал, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн хамт олон эмнэлэг, сургалтын цогцолбороо Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо буюу бидний сайн мэдэх Амгаланд байгуулахаар болсон байна. Уг цогцолбор 1500 ортой дотуур байр, хичээлийн байр, багш ажилчдын орон сууц, соёл, спортын төвөөс бүрдэх юм байна. Сургуулийн хамт олны саналыг Засгийн газар дэмжиж, газрыг олгох асуудлыг нийслэлтэй хамтран шийдсэн нь эдүгээ биелэлээ олж байгаа нь энэ. Хамгийн гол нь Цогцолбор ашиглалтад орсноор эмч, эмнэлгийн ажилтан бэлтгэх сургалтын чанар, орчин сайжрахаас гадна 12 мянга гаруй оюутан, 1000 гаруй багш, ажилчин хотын төвийн А зэрэглэлийн бүсээс шилжиж тэр хэрээр замын хөдөлгөөний түгжрэл буурах сайн талтай гэдгийг энд онцлох байна. Эцэст нь хэлэхэд, ядах нь ээ, хотын төвд зай талбай булаалдан орших төрийн өмчийн таван их сургууль, хувийн хэвшлийн СЭЗДС, "Этүгэн", "Шхихутаг", Хүмүүнлэгийн ухааны дээд сургуулийг хотоос гаргахад л 100 гаруй мянган оюутан их хотын түгжрэл тэр хэрээр буурна шүү дээ. Болж өгвөл дагуул хотууд руу "үдэх" хэрэгтэй байгаа юм. Ажилгүйдэл газар аваад энэ үед нэгэн суурин газрын хүн ам 1000 оюутан, 300 гаруй багш ажилчид тэдний ар гэрээр бүл нэмэхэд эдийн засаг нь тэр хэрээр өсөн нэмэгдэж л таарна.

## ЦАГ ҮЕ

# Д.БЯМБАСҮРЭН: ҮНДСЭН ХУУЛ ТӨРИЙГ ТОЛГ

Г.ГАНЧИМЭГ

*Монгол Улсын Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэнтэй Үндсэн хуулийн өөрчлөлт шинэчлэлт цаг үеэ үнэхээр олсон эсэх, мөн манай улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлыг юу гэж тольдон суугаа зэрэг уншигчдын хамгийн их сонирхож буй сэдвээр ярилцсан юм.*

**-Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулъя гэдэг саналыг дэвшүүлж олон жил ярьж байсан л даа. Гэхдээ эцэг хуулиар хамаагүй оролдохгүй гэдэг үзэл баримтлал давамгайлж ирсэн. Харин өнөөдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой хэлэлцүүлэг эхэлчихлээ. Ер нь энэ цаг үед Үндсэн хуулийг өөрчлөх нь зөв юм уу, буруу юм уу?**

-Үндсэн хууль гэдэг бол тухайн улс орны төр засаг нь ард түмэнтэйгээ байгуулсан хамгийн том гэрээ юм л даа. Тиймээс улс орны амьдралын зохион байгуулалтын үндсэн зарчмуудыг тогтоож өгдөг. Нэгэнт баталсан Үндсэн хуулиар тогтоосон зарчмууд нь цаг хугацаа болоод хөгжил, төлөө үйлчлэхгүй шүү дээ. Төрд орсон эрх мэдэлтнүүд, тэдний бүлэглэлд үйлчилдэг жам тогтлоо. Монголын эдийн засгийг ялзрааж, ядууруулж байгаа нэг гол хүчин зүйл нь энэ юм. Гэтэл Үндсэн хуульдаа хүмүүнлэг, энэрэнгүй иргэний ардчилсан нийгмийг байгуулна гэж зорьсон улс. Одоогийн байдлаар олигархи засаглалын тогтолцоо биднийг хамгийн зэрлэг, мөнгөний чимээнээр асуудлыг шийддэг хөрөнгөтний нийгэм рүү чирээд явчихлаа шүү дээ. Тиймээс бид Үндсэн хуулийнхаа томъёоллыг өөрчлөхгүй яг энэ замаараа, олигархиудын засаглалаар явах уу гэдэг нь нэгдүгээр асуудал. Хоёрдугаарт, Үндсэн хуулиар улс орны амьдралын гол дүрэм журам, нийгэмд шударга ёсыг тогтооно гэж төрийн ажиллагааны үндсэн зарчмыг бичсэн. Шударга ёс, тэгш эрх, ардчилал, хуулиа дээдлэх дөрвөн зарчим байгаа шүү дээ.

**-Төрийн соёрхолт яруу найрагч Р.Чойном 1960-аад оны дундуур “Шударга ёс хаана байна” гэж бичиж, магадгүй хашгирч байсан байх. Гэтэл өнөөгийн нийгэмд ч тэр шударга ёсны зарчим тогтсонгүй. Эрх мэдэлтэй хүмүүс юу ч хийж болдог, хуулийн хариуцлага** сайхан үгээр худал амлалт өгсөн. Хүүхдийн мөнгө, иргэн бүрт 1-1.5 сая төгрөг гээд элдэв янзын юм амласаар байгаад хамгийн сүүлчийнхээ амлалт дээр будлиад л сууж байна шүү дээ. Шударга ёст нийгэмд хүн үнэний хорвоод амьдарч, алсыг харж, ирээдүйдээ төдий чинээ итгэлтэй амьдрах ёстой. Гэтэл өнөөдөр ийм итгэл алга. Төр засаг, улс төрийн намууд нь юу ч амлаж болдог. Гэхдээ тэр нь дандаа худал байдаг, ийм л замаар орчихлоо. Сүүлийн 10 орчим жил 2007 оны дунд үеэс эхэлсэн эдийн засгийн ужиг хямрал үргэлжилж байна. Эдийн засаг бол манай амьдралын үндэс. Улсын төсөв гэдэг бол төрийн албанд ажиллаж байгаа бүх хүний амьдралын эх үүсвэр төдийгүй бусад салбартаа жишиг болж явдаг зүйл. Амьдралын хэм хэмжээг тогтоодог, төрийн ажилтны цалин ямар байна бусад салбар түүнийг харж байж цалингаа тогтоодог шүү дээ. Гэтэл манай 1992 оны Үндсэн хуульд эдийн засаг, санхүүгийн засаглалын тухай ганц ч үг, өгүүлбэр, бүр үнэр ч байхгүй. Соёлжсон орнуудад бол Үндсэн хуульдаа санхүүгийн засаглалаа оруулдаг. Тухайлбал, парламент нь Засгийн газраас оруулсан төсвийг нэмж болохгүй гэдэг ч эрх өгнө” гэсэн чинь долоохон хоногийн дотор нөгөөдөх нь батлагдаад гараад ирдэг байгаа. Ингэсээр яваад улсын маань төсөв хэт данхайгаад ДНБ-ийхээ 40 хувьд хүрлээ. Социалист нийгэмд, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай байхад 36 хувьтай л байсан юм шүү дээ. Үндсэн хуулиараа үүнийг зохицуулахгүй бол үе үеийн УИХ, Засгийн газар өөрсдийнхөө сонирхлоор л яаж л бол яаж өөрчилж, хямраажболдогийг бид хангалттай харлаа. Ер нь одоогийн байдлаас харахад, манай төрийн тогтолцооны хамгийн эмзэг, хамгийн сул дорой бүтэц нь УИХ, Засгийн газар болоод байна.

**-Төрийн албанд ураг төрлийн томилгоо хийгдэж, “цус ойртсон”. Үүнээс болж “Монгол төрийн дархлаа суларч байна” гэж зарим хүн үздэг юм билээ?**

-Аргагүй шүү дээ. УИХ нь дандаа амьдралаа сайжруулах хүслээр орж ирсэн хүмүүсээс голчлон бүрдэж байна. Тэгээд тэд зүгээр байхгүй, үр ачаа Засгийн газарт томилдог. Сүүлийн хэдэн Засгийн газрыг аваад үзье л дээ. Ер нь 1996 оноос хойш 11 Засгийн газар солигдсон. Солигдох бүрдээ Засгийн газрын чанар маань маш чухал хүн гэдгийг мэднэ. Гэхдээ бид сүүлийн үед Монгол Улсын Ерөнхий сайдыг гадаадын баячуудын гарт байгаа хүмүүсээс томилдог болсоныг харлаа шүү дээ. Сайдууд нь хэн болдог, одоо ч хэн байгааг харж л байна. Сангийн сайд хэн байна вэ. Уул уурхайн сайд хэн байна вэ гэдгийг харж л байна шүү дээ. Ийм нөхцөлд Ерөнхий сайдын эрх мэдлийг нэмнэ, өөрийнхөө дураар сайдуудаа томилог гэвэл биш л дээ.

**-Тэгвэл яг өнөөдөр Үндсэн хуулиа өөрчлөх нь зөв юм уу, үгүй юм уу. Та юу гэж бодож байна?**

-Одоогийн санаачлаад хэлэлцүүлж байгаа Үндсэн хуулийн өөрчлөлтийн төсөл бол үг хуйвалдсан, ямар нэгэн байдлаар төрийн эргэлт хийх арга гэж би хувьдаа үзэж байна. Яагаад гэвэл, Монгол төрийг толгойгүй болгож байна. Монгол төрийн шийдвэр гаргах гол асуудлыг хамгийн арчаагүй, сул дорой зангилаан дээр нь буюу Засгийн газарт аваачиж тавих гээд байгаа юм. Ийм нөхцөлд одоогийн Үндсэн хуулийг өөрчилбөл цаашид явуургүй. Одоо нэг улс төрийн хүчин УИХ-ын суудлын ихэнхийг авчихсан, 65 суудалтай, тэгээд түүгээрээ төрөө бариад Үндсэн хуулиа батална гэвэл буруу.

> ...Бид Оюутолгойн гэрээг баталснаас хойш ер нь Монгол Улс өөрийнхөө баялгийг захиран зарцуулах, өмчлөх чадваргүй юм байна гэдгээ дэлхий нийтэд харуулсан шүү дээ. Одоо Тавантолгой, тэгээд Харганат, Баянхөндийн гээд том том орд байна. Энэ баялгаас хүртэхээр санаархаж байгаа гадаад, дотоодын элдэв улс ерөөсөө Монголд нэгдмэл төрийн бодлого явуулах боломжгүй болгож, хэн дуртай нь түүнийг шийдэж гэрээнд гарын үсэг зурах байдал руу түлхэж байна л даа...

нийгмийн өөрчлөлтийн явцад доголдоод эхэлбэл нэмэлт, өөрчлөлт оруулаад явдаг. Энэ бол хүн төрөлхтний түүхэн зарчим. Бид 27 жилийн турш энэ Үндсэн хуулиар явлаа. Мэдээж, энэ хооронд ард түмэн маань эрх чөлөөтэй болж, улс орон маань тусгаар тогтнох бүрэн эрхээ гартаа авлаа гэж тунхаглалаа. Ардчилсан орнуудын нэр хүндтэй гишүүн болсон. Ярьвал их зүйл бий. Гэтэл нөгөө талд нь цаашид тэвчиж болохгүй хүнд асуудлууд хуримтлагдлаа шүү дээ. Тухайлбал, бид Үндсэн хуулиараа төрийн бүх эрх мэдэл ард түмний гарт байна гэж заасан. Үндсэн хуулиараа зургаан удаа сонгууль явууллаа. Эргээд харахад, төр маань олигархи бүлэглэлийн гарт орчихоод байна. Монгол Улс таван Ерөнхийлөгч сонгоход сүүлийн гурван Ерөнхийлөгч Н.Багабанди, Н.Энхбаяр, Ц.Элбэгдорж нар төрийн доройтол, ялзралын тухай ярилаа шүү дээ. Тэгээд одоогийн Ерөнхийлөгч Х.Баттулга энэ тухай ярьж байна. Тиймээс энэ одоо юу болоод байна вэ гэдэг асуудлыг тодруулалгүй цааш явбал мухардмал байдалд орно гэсэн үг.

**-Олигархи бүлэглэлийн засаглал Монголд яаж тогтов, Та үүнийг Үндсэн хуультай холбоотой гэж үзэж байх шиг байна?**

-Бид одоогийн Үндсэн хуульдаа найман удаа нам гэдэг үгийг хэрэглэж, улс орон маань намаасүүссэнтөрзасагтайбайна гэсэн зарчмыг тодорхойлж, 76 гишүүнтэй УИХ бол төрийн эрх барих дээд байгууллага мөн гээд тогтоочихсон. Эхний сонгуулиудын үед ард иргэд өөрсдийнхөө дунд нэр хүндтэй, итгэл хүлээх чадвартай хүмүүсээ сонгоод л явж байлаа. Гэтэл яваа яваандаа хөрөнгө мөнгөтэй бүлэг нь тодроод ирсэн. Энэ хэрээр улс төрийн намууд санхүүжиж, нийгэмд оршин тогтнохын тулд төрийн суудлыг мөнгөөр худалдаж, одоо МАН-ынхан 60 тэрбумын тухай ярьж байна. Энэ нь баримттайгаар дэлгэгдэж, нийтэд мэдэгдэж байгаа зүйл нь. Үнэндээ аль ч улс төрийн намууд хөрөнгө мөнгөтэй хүний гар харж, тэднийг УИХ-д тавьдаг нь нууц биш. Тэгээд тэд нь нөгөө зарсан мөнгөө хэд нугалж авахыг бодоод төрийг бизнес болгочихож байгаа юм. Ингэж яваа хүмүүс Монголын ард түмний нийтлэг эрх ашгийн



**хүлээдэггүй, нийгмийн баялгийн хуваарилалт ч тэгш биш байгаа нь иргэн хүний хувьд надад таалагдахгүй байна. Өнөөдөр олон хүн яг ийм бодолтой байгаа?**

-Монголын баялаг 100 хувь цөөнхийн гарт, тэр хүмүүсийн ард байгаа гадаад, дотоодын эздийн гарт төвлөрч эхэллээ. Энэ нь нийгэмд баян, ядуугийн ялгарал маш хүчтэй явагдахад нөлөөлсөн юм. Улс төрийн намууд ч сүүлийн хэдэн сонгууль дараалан янз бүрийн юм уу. Улс орны эдийн засгийг доройтуулах, улсад хохирол учруулах санал санаачилгыг УИХ-ын гишүүд гаргах эрхгүй ч гэдэг юм уу иймэрхүү заалтууд байдаг. Манайд ямар байна вэ гэвэл 2009 оноос эхлээд Засгийн газар, парламент хоёрын учир нь олдохоо болиод заримдаа Засгийн газар нь УИХ-аа хахуульддаг болчихсон. Үүний нэг жишээ нь 2009 оны төсвийн тодотгол батлагдахгүй болохоор нь “УИХ-ын гишүүдэд нэг, нэг тэрбум төгрөг зарцуулах яаж хамгаалах юм бэ, дотроо элдэв өнгийн Үндсэн хуулиа зөрчсөн санаархлууд, элдэв оролдлогоос яаж хамгаалах вэ гэдэг чинь нарийн асуудал. Үүнд анхаарах хэрэгтэй. Гэхдээ гол асуудал нь дээр дурдсан хэдэн зарчмын асуудал Үндсэн хуульд шийдлээ хүлээж байгаа юм.

**-Гэхдээ, Та ч бас саяхэллээ, монголчууд ярьдаг даа “Чоныг амнаас гараад барын аманд орно” гэж, үүн шиг янз бүрийн бүлэглэл өөрсдийн эрх ашгийг хамгаалсан элдэв янзын санаархлаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нэрийн дор оруулчих юм биш байгаа гэдэг айдас, хар заримд нь байна?**

-Үндсэн хуулиа өөрчлөх нэрийн дор ярьж байгаа зүйлүүдийг ажиглахад, гурван үндсэн чиглэл харагдаж байна. Нэг нь энэ гол асуудлуудаа шийдье, төрийнхөө эрх мэдлийг ард түмэндээ өгөөд олигархи засаглал ч гэдэг юм уу энэ гаж тогтолцооноос найдвартай хамгаалах дархлааг бий болгоё гэсэн санал байна. Нөгөөдөх нь, давхар дээл, төрийн боловсон хүчин зэрэг ер нь амьдралд тулгараад байгаа асуудлуудыг тусгайлах нэг санал байна. Энэ бол эрүүл санал. Харин гуравдахь нь Үндсэн хуулийг өөрчилнө гэдэг нэрийн дор Монголын төрийг бүр толгойгүй болгоод гадаадын хэн ч ирсэн тавган дээр тавиад урдаас нь бариад суухад бэлэн байдалд оруулах ийм байдал ажиглагдаж байна. Бид Оюутолгойн гэрээг баталснаас хойш ер нь Монгол Улс өөрийнхөө баялгийг захиран зарцуулах, өмчлөх чадваргүй юм байна гэдгээ дэлхий нийтэд харуулсан шүү дээ. Одоо Тавантолгой, тэгээд Харганат, Баянхөндийн гээд том том орд байна. Энэ баялгаас хүртэхээр санаархаж байгаа гадаад, дотоодын элдэв улс ерөөсөө Монголд нэгдмэл төрийн бодлого явуулах боломжгүй болгож, хэн дуртай нь түүнийг шийдэж гэрээнд гарын үсэг зурах байдал руу түлхэж байна л даа. Ийм нөхцөлд Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийсэн нөхөд Ерөнхийлөгчийн эрхээ хязгаарлах гэж байгаа юм. Төрийн тэргүүн гэдэг бол төрийнхөө бүх салаа мөчрүүдийн бодлого, үйл ажиллагаанд координац хийж, дотор нь зохицуулдаг хүн байх ёстой. Тэгж байж л тэр хүн төрийн тэргүүн байна. Ингэхгүй, эрхийг нь хязгаарлаад УИХ-аас сонгодог болъё гэж ярьж байна билээ. Ийм байдалд хүрвэл төрийн тэргүүн УИХ-ын гишүүдийн гарт орчихно шүү дээ. Аз болоход, одоо төрийн тэргүүнээ ард түмнээсээ сонгодог хэвээрээ. Гэхдээ эрх мэдэлгүй, бэлгэдэл төдий Ерөнхийлөгч үлдээх гээд байна шүү. Тэгээд л Ерөнхий сайдын эрхийг нэмье гээд байгаа юм. Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хууль бүх ард түмний хувь заяаны асуудал. Түүнд парламентад суудалтай бүх нам, тэр тусмаа Ерөнхийлөгч нь орж байж энэ асуудлыг шийднэ шүү дээ. Гэтэл одоогийн шинэ Ерөнхийлөгчийн санал Үндсэн хуулийн өөрчлөлтийн төсөлд байхгүй. Миний бодлоор энэ асуудлыг зөв шийдье гэвэл, цаашид Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр төсөл боловсруулахдаа хариуцлагатайгаар УИХ нь ч, Ерөнхийлөгч нь ч, Засгийн газар нь ч, тэр парламентад суудалтай намууд нь ч ороод энэ төслөө дахиж боловсруулах хэрэгтэй. Ингэхгүйгээр зүгээр нэг худал үнэн яриа, ухуулга хийж байгаад хууль батална гэвэл бүтэхгүй. Нөгөөтэйгүүр, Монгол орон 2000 гаруй жилийн түүхтэй төрт ёсны соёлтой, өөрийн гэсэн орчин нөхцөлтэй, хоёр их гүрний дунд байдаг, хоёр талаас нь яаж ч нөлөөлж болохуйн эмзэг орчинд байгаа улс шүү дээ. Ийм нөхцөлд төр нэг толгойтой байх хэрэгтэй. Чингис хаан хоёр толгойтой могой тэргэн доогуур орж үхдэг юм гэж сургасан. Одоо Монголын төрийг гурван толгойтой болгох гэж оролдоод байна. Ийм байж болохгүй. Цаашид үүнийгээ харна биз. Мөн давхар дээл, төрийн боловсон хүчний асуудлыг шийдэх л хэрэгтэй. Гэхдээ хамгийн гол асуудал зарчмаа шийдэхгүйгээр тодорхой хэдэн асуудал нэрлэчихээд цаад талд нь Монголын төрийг сулруулах, яваандаа төрийг нийгмийнхээ өмнө хариуцлага хүлээх чадваргүй болгох ийм алхмуудыг хийвэл аюултай.

**-Гадаад, дотоодын хөрөнгө мөнгөтэй хүмүүс УИХ-д суудалтай намуудтай нийлж байгаад өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалсан хууль батлуулдаг гэх юм билээ. Ийм нөхцөлд Үндсэн хуулийг өөрчилбөл яг хэний эрх ашигт нийцүүлэх вэ гэдэг нь эргэлзээтэй л юм байна?**

-УИХ-ын дарга хүртэл “Захиалгат хуулиуд явж байна” гэж гомдол тавиад сууж байхыг бид олон удаа харлаа шүү дээ. Гадаадынхны эсвэл нэг компанийн эрх ашигт нийцүүлээд хууль гаргадаг. Тэр нь сүүлдээ өөрчлөгддөг. Тэгээд улс төрийн тогтворгүй байдал, төрийн бодлого нь тодорхойгүй байна гэсэн дүгнэлтэд хүрээд бид чинь түүнээсээ болоод

ЦАГ ҮЕ



# ...ИЙГ ӨӨРЧЛӨХ НЭРИЙН ДОР МОНГОЛЫН ...ОЙГҮЙ БОЛГОХ ГЭЖ БАЙНА

гасалж явдаг улс шүү дээ. Жишээлбэл, Оюутолгойг ашиглалтад орохын өмнө 2005 оноос эхлээд л лобби бүлэг бий болоод татвар, ашигт малтмалын хуулийг өөрчилсөн. Энэ мэтээр олон өөрчлөлт хийж байгаад арчаагүй гэрээ байгуулаад одоо Оюутолгойн орлого Монголд орж ирэхгүй байна шүү дээ. Тэр байтугай бүтээгдэхүүний ч тооцоонд орохгүй байна. Оюутолгой ашиглаж байгаа хүдрийнхээ хэмжээгээр бол жилд 17 тонн орчим алт гаргадаг. Алтаа тусад нь үнэлж худалдах ёстой. Гэтэл саяхан би ҮСХ-ны мэдээллийг харж байхад манай гадагш нь худалдсан алт энэ жил 5.4 тонн байна л даа. Тэр нь манай Монголын нутагт алт олборлож байгаа дагнасан үйлдвэрүүдийн гаргасан алт. Оюутолгойн алт бол ерөөсөө тооцоонд ороогүй байна шүү дээ. Тэр 17 тонн алтыг нэг грамм нь 100 мянган төгрөгөөр бодоход хэд болох вэ. Асар өндөр тоо гарна биз дээ. Монголын төрийн ийм арчаагүй байдал нь эргээд эдийн засгийн шинэ колончлогчид, бурхан шиг царайлж, буян амалсан гадаадын луйварчид орж ирээд баялгийг маань дураараа эзэмшихэд бэлэн нөхцөл бүрдүүлж байна шүү дээ.

**-Сүүлийн үед дэлхийн улс орнууд тогтвортой хөгжлийн бодлогыг их ярьж байна. Ногоон эдийн засгийг хөгжүүлэх зорилгыг тавьдаг болжээ. Манай улсад тогтвортой хөгжил нь ч байхгүй, ногоон эдийн засаг нь ч байхгүй. Энэ нь тогтворгүй улс төрөөс л болсон гээд байх юм?**

-Шалтгаан нь олон л доо. Тогтвортой хөгжил гэдэг чинь хөгжлийн огт өөр философи. Хүнээ хөгжүүлэх, амьдрал ахуйг нь өөд татах, хүртээмжтэй байх тухай л асуудал юм шүү дээ. Гэтэл бид цөөхөн хэдэн баячууд нь л болж бүтэж байх бодлого явуулаад байна. Төрийн эрхэнд байгаа улс төрийн намууд маань ч ингэж хандаж байна. Одоогоор улс төрийн аль ч нам, МАН ч, АН ч ялгаагүй үзлийн мухардалд орчихоод байгаа юм. Гаднаас нь хараад зангидаад хэлбэл, либериализмийн шавар дотор байгаа чөдөртэй морь шиг л байна шүү дээ. Чөдөртэй морь тэр шавар дундаас гарч чадахгүй. Улс төрийн намууд маань яг ийм байна. Үзлийн мухардалд орчихсон. Нөгөөтэйгүүр, төр засаг нь сонгуулиас сонгуулийн хооронд савлаад, нэг нь гарч ирээд нөгөөгийнхөө хийсэн юмыг үгүйсгээд байхаар зэрэг Монгол орон хөгжлийн чиг шугам дээр хүчээ зангидах боломж бүрдэхгүй. Үүнээс болоод улс орны хөгжлийн цэгцтэй бодлогыг томьёолж, үүн дээрээ нөөц бололцоогоо төвлөрүүлж чадахгүй байна. Монгол Улс 1995 оноос хойш хөгжлийн үзэл баримтлалаа таван удаа баталлаа. Аль нь ч хэрэгжээгүй. Хэрэгжих ч боломжгүй. Яагаад гэвэл улс төрийн хүчнүүд нь өөрсдөө ингээд цөөн хэдэн баячуудын бүлэглэлд үйлчилж байна. Тэд чинь хоорондоо өрсөлдөөд нэг нь нөгөөгийнхөө юмыг булааж авах, нэгнийхээ хийснийг нөгөөдөх нь үгүйсгэх байдалтай явж байна шүү дээ. Үүнээс гарч байж хөгжлийн тухай асуудлыг ярина. Түүнээс биш ойрын таван жилд энэ тухай ярих үндэс байхгүй.

**-Ардтүмэн гэнэн итгэмтгий хэвээрээ л байгаа шүү дээ. Эрх баригч хоёр хүчинд итгэл алдрангуут гуравдагч хүчнийг хүсч байна. Гэтэл үнэндээ гуравдагч хүчин тодотголтой жижиг намууд нөгөө хоёр том намынхаа халаасанд байдаг?**

-Гуравдагч хүчин үзлээрээ л гарч ирэх ёстой. Нам гэдэг бол ямар нэгэн бизнесийн байгууллага биш. Нам гэдэг үзлийн байгууллага. Улс орныхоо явах зам мөрийн талаарх үнэн үзэлтэй, түүнийгээ олон түмэндээ хүргэдэг. Гуравдагч хүчин ийм л маягаар төрд гарч ирнэ. Одоо манайд гуравдагч хүчин яагаад гарч ирж чадахгүй байна вэ гэвэл энэ хоёр том нам чинь мөнгөөр сонгуульд орж байгаа юм. Хэдэн зуун тэрбум төгрөгөөр орж байна. Тайландаа бол бага тоо тавихаа мэднэ л дээ. Ингэхээр бусад жижиг нам олон түмний дунд хүрч ажиллах ямар ч боломжгүй. Мөнгөний сонгууль яваад байна. Харин төрийнхөө эрх мэдлийг ард түмэндээ өгч бариулаад үнэхээр тэд сонголт хийх боломжтой бол улс төрийн хүчин үзлээрээ гарч ирнэ. Одоо бол мөнгөөр гарч ирээд энэ боломжийг нь хаагаад байгаа юм шүү дээ. Үндсэн хуулийн өөрчлөлтийн талаар янз бүрийн санал байдаг л даа. Түүний нэг нь Ардын их хурлыг сэргээж байгуулъя гэдэг. Тэр бол зөв. Бүх сумаасаа төлөөлөлтэй Ардын их хурал байгуулаад түүнээсээ олон түмэн дэх рейтинг, нэр хүндийг нь харгалзаж хууль тогтоох хурал УИХ-аа байгуулаад Засгийн газрынхаа ажлыг дүгнэдэг, хянадаг болбол мөнгө зарах хэрэггүй болно. Улс төрийн намууд ч жинхэнэ үзлээрээ төрд гарч ирдэг болно. Одоо ингэхгүй, зарсан мөнгөөрөө, тэр мөнгө нь гадаадын хүний ч мөнгө байж магадгүй байхад маш их эрсдэлтэй.

> ...Оюутолгой ашиглаж байгаа хүдрийнхээ хэмжээгээр бол жилд 17 тонн орчим алт гаргадаг. Алтаа тусад нь үнэлж худалдах ёстой. Гэтэл саяхан би ҮСХ-ны мэдээллийг харж байхад манай гадагш нь худалдсан алт энэ жил 5.4 тонн байна л даа. Тэр нь манай Монголын нутагт алт олборлож байгаа дагнасан үйлдвэрүүдийн гаргасан алт. Оюутолгойн алт бол ерөөсөө тооцоонд ороогүй байна шүү дээ. Тэр 17 тонн алтыг нэг грамм нь 100 мянган төгрөгөөр бодоход хэд болох вэ. Асар өндөр тоо гарна биз дээ...

**-Сүүлийн үед улс төр ч их савалгаатай байх боллоо. Энэ нь нийгмийн бүхий л салбарт нөлөөлж байна?**

-Бид сүүлийн хоёр жил сонгууль хийлээ. МАН-ынхан мэргэжлийн Засгийн газар байгуулаад ард түмний амьдралыг сайжруулна гэж амлаж гарч ирсэн. Ингэхдээ жил тутамд эдийн засгаа долоон хувь өсгөнө гэсэн шүү дээ. Эхний жил нь баахан зовлон тоочиж байгаад өнгөрөөсөн. Сүүлдээ мэргэжлийн засаг ч байхгүй, нөгөө амьдрал сайжруулах зорилго ч байхгүй болсон чинь хүмүүс ууртай байсан л даа. Гэтэл энэ жил дахиад Ерөнхийлөгчийн сонгууль боллоо. Энэ үеэр болсон үйл явдлуудыг хараад хүмүүс “За даа, манайхан нэг л болохгүй байна” гэдэг ойлголттой л хоцорлоо шүү дээ. Тогтолцоо маань нэг л явж өгөхгүй, зовлонтой байгаа юм байна гэдгийг ойлгосон. Гэтэл өмнөх сонгуулийн үед гарч ирсэн тодорхой асуудлууд буюу 60 тэрбум зэрэг элдэв өнгийн асуудлууд одоо ч олон түмнийг бухимдуулаад байна л даа. Одоо эрх баригч улс төрийн хүчний дотор хүчтэй, том задрал явагдаж байна. Энэ нь нэг талаасаа эрүүл зүйл. Яагаад гэвэл, бугшсан бузар булай зүйлээ гаргаж цэвэрлэх нь Монголын эрх ашигт нийцнэ, нэг талаасаа. Гэтэл Засгийн газар нь ч бас дотроо зөрчилтэй байна. Ерөнхий сайд, Шадар сайд нь хоорондоо зөрчил тэмцэлтэй байгааг бүгдээрээ л харж байна шүү дээ. Дээрээс нь тагнуул, цагдаа, хүчний байгууллагууд үүн дээр нэмээд Авилгатай тэмцэх газар улс төрийн хараат байдалд орчихлоо шүү дээ. Энэ нь олон түмнийг улам эвгүй сэтгэгдэлтэй болгоод байгаа юм. Уг нь тагнуул, цагдаа, Авилгатай тэмцэх газар улс төрийн байгууллага биш шүү дээ. Тэд чинь тусдаа, мэргэжлийн байгууллага байх ёстой.

**-“Ахаа намайг бодоорой” гээд байгаа юм шиг мөрдэстэй дарга нар нь хэн нэгнийг дагаж намираад эсвэл хормой хотноос нь зүүгдээд байх онцгүй ч өнөөдөр дээр, дооргүй л энэ талаар ярьж, “Сайдынхаа амралтын өрөөнөөс нэг хурандаа гарахаа больж гэнэ” гэх мэтээр л жиг жуг хийцгээж байна шүү дээ?**

-Цаад талдаа эдгээр байгууллага өөрсдөө бас цэвэр биш гэдэг нь иймэрхүү байдлаар илэрч харагдаж байгаа юм шүү дээ. Ер нь сүүлийн үед “Авилгатайтэмцэхгазраарядаг юм. Татан буулгая” гэдэг санал хүчтэй явж байна. Харахад, тэр бол үнэн. Авилгатай тэмцэх газар байгуулагдаад 10 гаруй жил боллоо. Юу хийсэн юм бэ.

**-Ганцхан Ерөнхийлөгч асан Н.Энхбаяртай л тэмцсэн юм биш үү?**

-Баахан жараахай шүүчихээд “Би загас барилаа” гэж ярьдаг хүүхэд шиг л харагдах юм байна шүү дээ. Ямар ч чадваргүй. Тэгсэн мөртлөө дээшээ, доошоо долигнож, улс төрийн захиалгаар ажилладаг. Саяхан У.Хүрэлсүхийг аваачаад “Хууль бусаар төрийн эрх мэдэл авах гэлээ” гэдэг дүгнэлт гаргаад прокурорт өгч байгаа юм. Тэр дүгнэлтийг чинь Авилгатай тэмцэх газар ч гаргадаг юм биш. Эрх мэдлийнх нь асуудал ч биш. Эндээс харахад, ер нь энэ байгууллага ажиллах чадваргүй болжээ.

**-Саяхан Засгийн газрыг огцруулъя гээд эрх баригч хүчин нам дотроо зөндөө л зөрчилдлөө. Ер нь энэ хэр үндэслэлтэй байсан бэ?**

-Засгийн газрыг огцруулж болохгүй. Хэрэв огцорвол МонголУлсдампуурнагээдярьж байсан л даа. Монгол Улс эдийн засгийн хүнд байдалд орсон нь хэдэн жилийн өмнөөс. Үүнийг бүгдээрээ л мэдэж байгаа. Бид 2018 онд нэг тэрбум 900 гаруй сая ам.долларын өр төлөх ёстойгоо мэднэ шүү дээ. Энэ нь Засгийн газрыг уях шатгаан биш. Анхнаасаа л өөрсдийгөө мэргэжлийн Засгийн газар гэж зарлаад, мэргэжлийн биш хүмүүсийг тавьсан. Уул уурхайн бодлогоо ч цэгцэлж чадахгүй, арчаагүй хэвээрээ л байна шүү дээ. Энэ Засгийн газар анх байгуулагдахдаа мөрийн хөтөлбөртөө боловсруулж оруулсан газрын тос болон зэс боловсруулах үйлдвэр, Багануурын цахилгаан станц, гангийн үйлдвэр хаана байна. Одоо цаана нь хоёрхон жил үлдлээ. Тэд хэчнээн түргэн ажиллалаа ч гэсэн хоёр жилийн дотор үйлдвэрүүдээ босгож амжихгүй. Ингээд амлалт нь худал болж байгаа юм. Ажиллаж байгаа арга барил нь гэвэл хөрөнгө мөнгөө дотроо хуйвалдаж, хуваагаад тэр баримт нь дэлгэгдэж байна. Концессын гэрээгээр гээд нэг компанид л 820 тэрбум төгрөг өгчихөж болохгүй. Ийм юм хийж байгаа Засгийн газар байх хэрэггүй л дээ, уг нь.

**-УИХ-ын зарим гишүүний увайгүй үйлдэл хэрээс хэтэрч, бүр Төрийн ордныг бузарлаж байна. Үүнд ард түмэн бухимдаж, зарим нь УИХ-ын гишүүнийг эргүүлээд татдаг болъё гэдэг саналыг ч гаргаж байна. Гэтэл эргүүлээд “Та нарын л сонгосон хүн. Хохь чинь” гэх өнгө аяс цухалзаад байх юм?**

-Одоогийн УИХ-д хүчин, хулгай, танхай дээрмийн хэрэгт холбогдсон хүн байна. Тэднийг хэн гаргаж байгаа юм. Намууд л мөнгө аваад нэрийг нь дэвшүүлж гаргасан шүү дээ. Ард түмэнд сонголт үүсгэхгүй, сонгуульд оролцох эрхийг нь худалдаж байгаа улс төрийн намууд гол хариуцлагыг нь үүрэх ёстой. Яах вэ, тэдэн дотор нийгэм, улсынхаа төлөө зүтгэе гэсэн хүмүүс бий л дээ. Гэхдээ дийлэнх олонх нь мөнгөөр гарч ирээд байхаар төрийн маань чанар ийм болоод байна шүү дээ. Ер нь одоогийн төрд ажиллаж байгаа хүмүүс дөрвөн жилийн дараа юу ч болоо билээ. Энэ хугацаанд л амжиж амьдралаа сайжруулъя гэдэг хандлагатай болчихоод байгаа юм.

**-Манай улс эдийн засгийн тусгаар тотнолоо алдсан алдаагаа залруулж, цаашлаад хэний ч өмнө нүүр бардам зогсох, эдийн засгийн чадвартай болох боломж байна уу?**

-Манай улс бол үлэмж баян орон шүү дээ. Гэтэл байгалийн баялгаа ашиглаж чадахгүй байна. Оюутолгой гэхэд 42 сая тонн зэс, 11 мянган тонн цагаан мөнгө, 1800 тонн алтны нөөцтэй орд юм. Эрдэнэт үйлдвэр 6.6 сая тонн зэсийн нөөцтэй хэр нь 40 орчим жил Монгол Улсын эдийн засагт ямар хүчтэй түлхэц өгч, гол багана нь болоод явж байна вэ. Гэтэл Оюутолгой нөөцийн төлбөрөө таван хувь болгуулчихаад ашгийн 20 хувиас өөр юу ч өгөхгүй, 34 хувьд чинь зээл өглөө гээд бид харин баялгаа өгсөн биш өөрсдөө өрөнд ороод хоцорлоо. Оюутолгой төр засгийнхантай гэрээ хийхдээ борлуулалтын бүх орлогоо гадаадад байршуулна гээд заачихсан. Ингээд бид хоосон тоо тэврээд хоцорлоо шүү дээ. Тэдэн сая тонн зэс гарч гэнэ гээд яриад суудаг болохоос биш мөнгө нь Монголд орж ирдэггүй. Баялгаа зөв эзэмшиж чаддаг болбол жижигхэн эдийн засагтай учраас Монгол Улс амархан босно.



Реклам, зар сурталчилгааны алба: **99173710**

# КИМ 6 ДАХЬ УДААГАА ЦӨМИЙН ЗЭВСЭГ ТУРШЛАА



Б.ДАВАА

Олон улсын шаардлагыг үл тоож, цөмийн зэвсэг, баллистик пуужингийн туршилтаа үргэлжлүүлж буй Хойд Солонгос тив алгасагч пуужинд суурилуулах боломжтой жижигрүүлсэн устөрөгчийн бөмбөгтэй болсноо олон улсад зарлав. KCNA агентлагийн мэдээлэлд залуу удирдагч Ким Жон Ун өөрийн эрдэмтдийн бүтээсэн устөрөгчийн бөмбөгийг биеэр үзэж, танилцсан тухай өгүүлсний зэрэгцээ гэрэл зургийг нь нийтэлжээ. Мөн өнгөрсөн долдугаар сард туршсан шинэ тив алгасагч баллистик пуужинд уг бөмбөгийг суурилуулахаар бэлтгэж байгаа тухай өгүүлсэн байна. Шинэ баллистик пуужин нь 10 мянган км зайд буюу АНУ-ын эх газрын аль ч цэгт цохилт өгөх чадалтай аж.

Зарим мэргэжилтнүүд Хойд Солонгосыг зургаа дахь удаагийн цөмийн зэвсгийн туршилтдаа бэлтгэж буй гэх мэдээллийг хиймэл дагуулын зурагт үндэслэн мэдэгдэж байсан юм. Тус улс дөрөв болон тав дахь цөмийн зэвсгийн туршилтаа 2016 онд гүйцэтгэсэн байдаг. Өнгөрсөн оны нэгдүгээр сард хийсэн туршилтаа устөрөгчийн бөмбөг байсан гэж мэдэгдсэн ч, салбарын мэргэжилтнүүд эргэлзэж байсан удаатай. Гэхдээ уг мэдээнд цөмийн зэвсгийн туршилтын талаар нэг ч үг, өгүүлбэр дурьдаагүй байна.

Гэтэл уг мэдээллээс хэдхэн цагийн дараа Хойд Солонгосын зүүн хойд хэсэг, Япон, БНСУ, хилийн орчмын бүс нутагт маш хүчтэй чичиргээн мэдрэгдлээ. АНУ-ын Геологийн судалгааны хүрээлэнгээс мэдээлснээр Хойд Солонгосын Сунжипэгамаас зүүн хойш 24 км зайд 6.3 магнитудын хүчтэй газар хөдөлсөн байна. Газар хөдлөлтийн гүн 0 км-т байжээ. Харин БНСУ-ын цаг уурын мэргэжилтнүүд Хойд Солонгосын хойд Хамгён мужийн орчимд өчигдөр 00:36 цагийн үед хүний хүчин зүйлийн нөлөөлөлтэй чичиргээн мэдрэгдсэн талаар хэвлэлд мэдээлсэн байна. Хүч нь Пхеньяны тав дахь цөмийн зэвсгийн туршилтаас 5-6 дахин, дөрөв дэх туршилтаас 11 дахин хүчтэй байжээ.

Чичиргээн ОХУ-ын хилийн орчимд ч ажиглагдсан аж. Владивосток дахь ОХУ-ын шинжлэх ухааны академийн салбар байгууллагаас мэдээлснээр хоёр улсын хилийн орчимд 4.5 магнитудын хүчтэй газар хөдөлсөн байна. Нэгэн гэрч “Хэдэн секундын турш газар чичирхийлж, ширээ, гэрлийн шил хөдөлж байсан. Маш их айсан. Цаашдаа юу болох бол гэдэгт би үнэхээр санаа зовж байна” хэмээн “NHK” агентлагт ярьсан байв.

Газар хөдлөлтийн чичиргээн бүс нутаг даяар мэдрэгдсэний дараа БНСУ-ын Ёнхап агентлаг эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн Хойд Солонгос зургаа дахь удаагийн цөмийн зэвсгийн туршилтаа хийсэн талаар дамжууллаа.

Пхеньян өнгөрсөн оны есдүгээр сарын 9-нд болсон Хойд Солонгос улсыг тунхагласны 68 жилийн ойн баяраар хийсэн цөмийн зэвсгийн туршилтаас хойш яг нэг жилийн дараа зургаа дахь удаагийн туршилтаа хийж буй нь энэ юм. Харин АНУ-ын Ерөнхийлөгчөөр Доналд Трамп сонгогдсоноос хойш анх удаа цөмийн туршилт хийж байна.

Пхеньян ч мөн устөрөгчийн бөмбөг амжилттай туршсанаа зарласан юм. Тус улсын төрийн өмчит KCNA агентлаг манай цагаар 14:30 цагийн орчимд зургаа дахь удаагийн цөмийн зэвсгээ туршсанаа зарлалаа. Тус мэдэгдэлд “Тив алгасагч баллистик пуужинд суурилуулах боломжтой жижигрүүлсэн устөрөгчийн бөмбөгийн туршилт амжилттай болсон. Туршилт өнөөдрийг хүртэлхээс асар их хүчтэй, найдвартай ажиллагаатай байлаа. Устөрөгчийн бөмбөгийн туршилт амжилттай болсоноор манай улсын цөмийн цэнэгт хошуугаа улам боловсронгуй, найдвартай ажиллагаатай болгох зорилт биелэлээ олох боломжтой боллоо” хэмээжээ.

Хойд Солонгосын энэ удаагийн туршилт НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн шийдвэрийг зөрчсөн төдийгүй АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампын байр суурь улам чангарахад нөлөөлөх нь гарцаагүй гэдгийг ажиглагчид хэлж байна. Түүнчлэн, БНХАУ, ОХУ, Олон улсын нийгэмлэгээс тус улсад тавих хориг арга хэмжээ, дарамт шахалт улам нэмэгдэж болзошгүй байгаа юм. Ээлжит туршилттай холбоотойгоор АНУ, Өмнөд Солонгос, Япон улсууд ямар хариу арга хэмжээ авахаа хэлэлцэж эхэлсэн байна. Хойд Солонгос долдугаар сарын 4, 28-нд хоёр удаа “Хвасон 14” пуужингийн туршилт хийсэн юм. Мөн наймдугаар сарын 29-нд Хвасон-12 дундын зайн тусгалт пуужингийн туршилт хийсэн бөгөөд тэр нь Японы Хоккайдо арлын дээгүүр өнгөрч, Номхон далайд унасан байдаг.

### ХОЙД СОЛОНГОСЫН ТУРШИЛТУУД

-2006 оны аравдугаар сарын 9-нд эхний цөмийн зэвсгийн туршилт

-2009 оны тавдугаар сарын 25-нд хоёр дахь туршилт

-2013 оны хоёрдугаар сарын 12-нд гуравдахь туршилт

-2016 оны нэгдүгээр сарын 6-нд дөрөвдэх туршилт

2016 оны есдүгээр сарын 9-нд тавдахь туршилт

2017 оны есдүгээр сарын 3-нд зургаа дахь туршилт

## Францын 15 иргэн аянганд ниргүүлжээ

Францын зүүн хойд этгээдийн Азерайллест энэ сарын 2-нд “Vieux Canal” хөгжмийн фестиваль зохион байгуулагджээ. Гэвч, тус наадам болж байсан газарт аянга бууж, 15 хүн гэмтсэн байна. Тэдний хоёрынх нь биеийн байдал туйлын хүнд байгаа гэнэ. Энэ талаар орон нутгийн албаныхан мэдээлсэн аж.

Аянга фестиваль ид дундаа өрнөж байх үед энд тэндгүй бууж эхэлсэн байна. Тухайн үед майханд байсан 60 гаруй насны эмэгтэй болон 44 настай эрэгтэй аянганд ниргүүлж, гэмтжээ. Аянга фестивальд оролцогчдын түр хоргодож байсан том майхан дээр буусан байна. Мөн ойролцоох моддын дээр ч бууж байжээ.

Байгалийн онц ноцтой үзэгдлийн улмаас гэмтсэн хүмүүст эмч нар анхан шатны тусламж үзүүлж ойролцоох эмнэлэгт хүргэсэн байна. Гэвч, аянганд цохиулсан 10 гаруй насны хоёр хүүхэд биеийн байдал нь хүнд, шокийн байдалтай эмнэлэгт хүргэгдэн эрчимт эмчилгээний тасагт шилжжээ. Фестиваль хоёр хоног үргэлжлэх төлөвлөгөөтэй байсан ч, аянгатай холбоотойгоор цуцлагдсан байна.

## Канбожийн сөрөг хүчний удирдагч баривчлагдлаа

Канбожийн хамгийн том сөрөг хүчин болох “Cambodia National Rescue” намын дарга 64 настай Кэм Сохаг эх орноосоо урвасан хэргээр өчигдөр нийслэл Пномпень хот дахь гэрээсээ цагдаагийнханд баривчлагджээ.

Тус улсын Засгийн газар түүнийг АНУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Хун Сений засаглалыг түлхэн унагахаар төлөвлөсөн хэмээн үзэж буй аж. Орон нутгийн зарим хэвлэлд Канбожийн Ерөнхий сайд Хун Сен “Эх орноосоо урваж, гадны улс оронтой хуйвалдсан” хэмээн “Cambodia National Rescue” намын дарга Кэм Сохаг буруутгасан талаар мэдээлсэн байна. Харин “Cambodia National Rescue” нам Үндсэн хуулийн хамгаалагдсан УИХ-ын гишүүнийг өнөөгийн хуулийн байгууллагынхан хууль зөрчин баривчилсан гэж мэдэгдэн, ямар нэг нөхцөлгүйгээр улс төрийн сүрдүүлгээ даруй зогсоохыг шаардлаа. Канбожид ирэх жилийн долдугаар сард парламентын бүх нийтийн сонгууль болох юм. Тус сонгуульд сөрөг хүчин ялалт байгуулах магадлал өндөр байгаа аж. Тиймээс энэ удаагийн баривчилгаа сонгуулийг угтан, сөрөг хүчин болох “Cambodia National Rescue” намын рейтингийг унагах улс төрийн зорилготой гэж зарим ажиглагчид үзэж байна.




## ОХУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд эмэгтэй хүн өрсөлдөж магадгүй

ОХУ-ын ирэх 2018 оны Ерөнхийлөгчийн сонгуульд өнөөгийн Ерөнхийлөгч В.Путинтай эмэгтэй хүн төрийн тэргүүн болохоор өрсөлдөж магадгүй гэж “Ведомости” сонин мэдээлсэн талаар РИА-Новости дамжууллжээ.

“Ведомости” сонин ОХУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газарт ойр эх сурвалжийн мэдээлэлд үндэслэсэн тус мэдээллийг хүргэсэн байна. Сонинд бичсэнээр, сонгуульд 5-7 хүн өрсөлдөнө гэж таамаглаж байгаа бөгөөд Социал демократ эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн Наталья Великая, Эцэг эхчүүдийн үндэсний хорооны тэргүүн Ирина Волынец, “Справедливая Россия” намын Төв зөвлөлийн гишүүн Ирина Петеляева гэсэн гурван эмэгтэй яригдаж байгаа гэнэ. Мөн телевизийн хөтлөгч Ксения Собчак ч өрсөлдөж магадгүй аж. “Ксения Собчак бол орчин үеийн залуу орос эмэгтэйчүүдийн тод төрх. Ухаалаг, олны анхаарлыг татаж чаддаг тэрбээр харин өөрөө ийм сонголт хийх үү гэдэг л сонин байна” хэмээн тус сонинд бичжээ.

Ирэх оны Ерөнхийлөгчийн сонгуульд Владимир Путин өрсөлдөх эсэх талаар түүний хүрээллийнхэн мэдээлэл өгөөгүй байгаа юм.

Өмнө нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд хоёр удаа эмэгтэй улстөрч өрсөлдөж байжээ.

### ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

Фарго Майнинг ХХК нь нээрээ өөрчлөн Фарго Материалс ХХК болгон өөрчилсөн тул хуучин нэрийг хүчингүйд тооцов.

НИЙГЭМ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

# АШУҮИС ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН НЭЭЛТЭЭ ХИЙЛЭЭ

Б.ДАВАА

"...Хүний их эмч гэдэг ур чадвар, мэдлэг, сэтгэл шаардсан нарийн мэргэжил. Хүссэн хүн бүр сайн эмч болж чадахгүй. Тиймээс та нар яг өнөөдрөөс эхлэн хариуцлагатай, өөрсдийгөө дайчилж, багш нарынхаа заасан зүйлийг ягштал биелүүлж, мэдэж, мэдэхийн зэрэгцээ хийж сураасай гэж чин сэтгэлээсээ хүсч байна...". Энэ үгийг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт АШУҮИС-ийн 2017-2018 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үеэр тус сургуулийн захирал, доктор, профессор Г.Батбаатар шинэхэн элсэгчиддээ хандан хэлсэн юм.

Тэртээ 1942 онд суурия засч, хүн ардынхаа эрүүл амьдралын төлөө дээд боловсролтой боловсон хүчнийг бэлтгэж эхэлснээс хойш АШУҮИС 75 дахь удаагийнхаа хичээлийн шинэ жилийн нээлтээ есдүгээр сарын 1-нд Эко цогцолбортоо зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагаанд УИХ-ийн дарга М.Энхболд, БСШУСЯ-ны дэд сайд Ё.Отгонбаяр, БСШУСЯ-ны төрийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч, АШУҮИС-ийнудирдах зөвлөлийн дарга Т.Ган-Эрдэнэ, ЭМЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат нарын хүндтэй зочид төлөөлөгчид, бүрэлдэхүүн сургуулийн эрдэмтэн багш нар, тус сургуульд шинээр элсэн орж, эмч болох эхний алхмаа хийх гэж буй нэгдүгээр дамжааны оюутнууд оролцсон юм.






Хичээлийн шинэ жилийн нээлтийн ёслолын эхэнд АШУҮИС-ийн захирал, доктор профессор Г.Батбаатар нийт элсэгчиддээ мэндчилгээ дэвшүүлсний зэрэгцээ "Энэ жил АШУҮИС үүсэн байгуулагдсаны 75 жилийн ой тохиож байна. Бид ойгоо аравдугаар сарын 4, 5-ны өдрүүдэд ёслол төгөлдөр тэмдэглэнэ. Өөрөөр хэлбэл, тэртээх 1942 онд эх орны дайны хүнд, хэцүү жилүүдэд Монгол Улс эх орондоо хүний их эмчийг, дээд боловсролтой боловсон хүчинг бэлтгэх түүхэн шийдвэр гаргаснаас хойш энэ жил 75 жилийн ойтойгоо золгож байна. Бид ойрын ирээдүйд Ази номхон далайн баруун бүсийн шилдэг 100 их сургуулийн нэг болох зорилт тавьж, үүнийхээ төлөө хичээн ажиллаж байна. Та нар үнэхээр азтай. Учир нь олон улсын эрх бүхий ХБНГУ-ын ASIIN гэх байгууллагаар магадлан итгэмжилсэн хөтөлбөрөөр суралцах анхны оюутнууд болох юм. Та нартаа баяр хүргэе. Мөн Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар их сургуулийн эмнэлгийг Монголдоо анх удаа барьж байна. Их сургуулийн эмнэлэг барих асуудал зөвхөн барилга байшин барих, тоног төхөөрөмжийн асуудал огтхон ч биш. Их сургуулийн эмнэлгийн тогтолцоог Монголд анх удаагаа үүсгэн байгуулж буйгаараа ач холбогдолтой билээ. Өнөөдөр манай сургуульд элсэн орсон оюутнууд их сургуулийн эмнэлгийн анхны суралцагчид байх болно. Мөн эмнэлгийнхээ хажууд сургалтын цогцолбор барьж байгаа. Энэ цогцолборын ч бас анхны суралцагчид нь та нар байх болно. Та бүхнийг азтай гэж хэлдэг нь иим учиртай юм" гэлээ.

## М.Энхболд: Эрүүл мэндийн салбарын 100 залууг Харвардад суралцуулна

АШУҮИС-ийн хичээлийн шинэ жилийн нээлтэд оролцсон хүндтэй эрхмүүдийн нэг нь УИХ-ын дарга М.Энхболд байв. Тэрбээр нээлтийн ёслолын үеэр эдүгээ 75 жилийн ойгоо угтаж буй их сургуулийн үе үеийн төгсөгчид, эрдэмтэн багш нарт мэндчилгээ дэвшүүлэхийн сацуу шинээр элсэн сурагцагчдад хандан хууль тогтоох байгууллагын төвшинд хэлэлцэн шийдвэрлэсэн үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл өгсөн юм.

УИХ-ын дарга М.Энхболд "Ирээдүйн Монголын иргэнийг эрүүл чийрэг, үнэ цэнэтэй хүн болгоход эрүүл мэндийн салбар хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол хүн дэлхийд хэрхэн үнэлэгдэх нь өнөөдөр энэ салбарт ажиллаж буй эмч нарын амжилтаас шууд шалтгаалах билээ. Манай улс 10 мянган хүнд ногдож буй эмчийнхээ тоогоор дэлхийн дундажаас 3-4 дахин илүү байдаг. Харамсалтай нь иргэдэд үзүүлж буй эрүүл мэндийн салбарын чанар, үйлчилгээ дэлхийн төвшнөөс дээгүүр байж чаддаггүй. Үүнийг засах, залруулах ирээдүйн жинхэнэ шинжлэх ухаанд суурилсан эрүүл мэндийн салбарын эрдэмтэн мэргэд энэхүү эрдмийн уурхайгаас төрөн гарна гэдэгт би итгэлтэй байна. Техник технологи хоног тутамд хөгжиж буй өнөөгийн нийгэмд зөвхөн энэ сургууль, энэ танхимын хүрээний сургалтаар бус, тив дэлхийн эрүүл мэндийн салбарт гарч буй өөрчлөлт, шинэ техник, технологийг илүү их суралцан шамдах хэрэгтэй шүү гэдгийг энэ дашрамд захья. Саяхан БСШУС-ын сайд Харвардын их сургуулийн Анагаах ухааны салбартай гэрээ байгуулсан. Энэ үйл ажиллагаанд танай сургуулийн удирдлага оролцож, эрүүл мэндийн салбарын 100 залуу боловсон хүчнээ Харвардын их сургуульд зайнаас сургахаар болсон гэдгийг дуулгахад таатай байна. Энэ бол Монголын эрүүл мэндийн салбар дэлхийн эрүүл мэндийн салбартай хөл нийлүүлэхэд нэг алхам урагшилж буй хэрэг. Дэлхийн аль ч улс оронд очсон эрүүл мэндийн сургалтын байгууллага эмнэлгийн үйлчилгээтэйгээ цогцоор үйл ажиллагаа явуулдаг. Их, дээд сургуулийн дэргэдэх эмнэлэг хамгийн өндөр чанартай байдаг гэж ч ярьдаг юм билээ. Харамсалтай нь энэ тогтолцоо манайд төдийлөн бүрэн дүүрэн хөгжиж чадаагүй.

АШУҮИС-ийн нийт ажилтан алба хаагчид та бүхэн хичээж, чармайсны дүнд 2014 оноос хойш Японы Засгийн газрын буцалтгүй тусламж, улсын төсвийн хөрөнгө, сургуулийн хувийн орлого гээд нийт 200 гаруй тэрбум төгрөгөөр их сургуулийн эмнэлэг байгуулах томоохон төсөл амжилттай хэрэгжиж байна. Гэхдээ цогцолбор баригдаж дуусахад хөрөнгө санхүүгийн асуудал тулгарч байгаа нь нууц биш. Тиймээс Засгийн газраас 2018 оны улсын төсөвт тусгаж, УИХ-д өргөн барьж байгаа. Түүнчлэн, эрүүл мэндийн салбарын сургалт, үйлдвэрлэл, эмнэлэг цогц байдлаар ажиллах эрх зүйн орчныг бий болгох нь хууль тогтоох байгууллагын анхаарвал зохих чухал асуудал болж байна. Тиймээс Эрүүл мэндийн яам, УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо хамтран төсөл боловсруулж байгаа. Ойрын үед батлагдаж, та бүхний ажиллах гол зарчим, эрх зүйн орчин шинэчлэгдэн, өөрчлөгдөх болов уу. АШУҮИС-ийн босгоор өнөөдөр анх удаа алхан орж буй оюутан залуус та бүхэн сонгосон эрхэм хүндтэй мэргэжилдээ эзэн нь байж, алдар цуутай сайн эмч нар болохын ерөөлийг дэвшүүлье. Эрдэм номын ариун цагаан буян үргэлж гийж бадарч байх болтугай" гэлээ.

## АШУҮИС–д эрдэм шинжилгээний 70 төсөл хэрэгжиж байна

АШУҮИС нь жил бүр 2000 гаруй мэргэжилтнийг бакалаврын 18, дипломын есөн хөтөлбөрөөр төгсгөж байгаа бөгөөд сургалтын бүх хөтөлбөрүүдээ БМИҮЗ-өөр магадлан итгэмжлүүлсэн юм. Мөн "Анагаах"-ийн хөтөлбөрөө ХБНГУ-ын ASIIN байгууллагаар олон улсад магадлан итгэмжлүүлж, сувилахуйн болон хөдөлмөрийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдээ олон улсын урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэжээ.

Эдүгээ АШУҮИС-ийн хэмжээнд эрдэм шинжилгээний 70 төсөл хэрэгжиж байгаа ажээ. Үүнээс ШУТДС-ийн санхүүжилттэй 11, олон улсын байгууллагын санхүүжилттэй 22, суурь судалгааны 10 төсөл хэрэгжиж байгаа юм байна. Түүнчлэн, энэ оны байдлаар гадаадын 21 багш ажиллаж, 72 оюутан суралцаж байгаагийн зэрэгцээ гадаадын урт богино хугацааны сургалтад 132 багшийг, оюутан солилцооны хөтөлбөрт дотоодын 56, гадаадын 48 оюутныг хамруулжээ. Мөн онд барилга байгууламж, сургалтын тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, урсгал засварын ажлыг нийт 6.4 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн гүйцэтгэсэн байна. АШУҮИС нь 2014 оноос эхлэн сургуулийн шинэ цогцолбор байгуулах 208.4 тэрбум төгрөгийн төслийг хэрэгжүүлж, Их сургуулийн сургалтын нэгдсэн эмнэлэг, Анагаах ухааны сургууль, Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн барилгууд баригдаж, 2018 онд ашиглалтад орох юм. Үүнд Японы Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 174 тэрбум, өөрийн хөрөнгөөр 9.4 тэрбум, улсын төсвөөр 1.66 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн бөгөөд цаашдын үйл ажиллагаанд 23.4 тэрбум төгрөг шаардлагатай байна. Үүнээс 14.3 тэрбумыг 2018 оны улсын төсөвт тусгахаар Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэсэнд тус их сургуулийн эрдэмтэн багш, оюутан судлаачид талархал илэрхийлж байв.

АШУҮИС нь өнгөрсөн наймдугаар сарын байдлаар нийтдээ 17981 үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлжээ. Үүний 1143 нь тус их сургуулийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн гэсэн тооцоо ч гарсан байна.

## Шилдэг оюутнуудад цагаан халад гардуулав

Монголын анхны их сургуулийн дэргэдэх нэгдсэн эмнэлэг, олон улсын стандартад нийцсэн номын сан, гарааны компаниуд гээд олон арван бүтээн байгуулалтын ажил АШУҮИС-аар овоглодог. Ази, Номхон далайн баруун эргийн бүсийн 100 шилдэг их, дээд сургуулийн нэг болох том зорилго өвөртөлсөн эдний хамт олон манай улсын эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтнүүдийн 90 гаруй хувийг бэлтгэн гаргадаг билээ. Тэдний олон жилийн хүч хөдөлмөр, чармайлтыг Монголын төр үнэлж өнгөрөгч долдугаар сард Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасан юм. Энэ үйл ажиллагаа ч сургуулийн түүхт 75 жилийн ойтой давхацсан байдаг.

Тэгвэл төрийн томоохон шагналыг хүртсэн тус сургуулийн босгыг алхан орж буй оюутан залуус ч манлайлагч, шилдгүүд байдаг ажээ. 2017-2018 оны хичээлийн шинэ жилд тус сургуульд 3000 орчим оюутан элсэн суралцаж байгаа юм байна. Тэдний дундаас Элсэлтийн ерөнхий шалгалтдаа 800 оноо авч, элссэн гурван оюутанд АШУҮИС-ийн хамт олон талархал илэрхийлж, басхүү урам хайрлан нээлтийн үйл ажиллагааны үеэр цагаан халад, чагнуур бэлэглэлээ.

БСШУСЯ-ны дэд сайд Ё.Отгонбаяр, БСШУСЯ-ны төрийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч, АШУҮИС-ийн удирдах зөвлөлийн дарга Т.Ган-Эрдэнэ, ЭМЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат нарын хүндтэй төлөөлөгчид Эко цогцолборын тайзнаа гарч, шилдэг элсэгчдэд тус халадыг нь гардуулан өгсөн юм. Үүний дараа тус сургуулийн сүлд дуу эгшиглэж, бүх нийтээр дуулснаар хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаа өндөрлөсөн билээ. Энэ үеэр бид шилдэг элсэгчидтэй уулзаж, сэтгэгдлийг нь сонссон юм.

## Б.Энхтуул: Эмч гэх эрхэм мэргэжлийг эзэмшихэд АШУҮИС туслана гэдэгт итгэлтэй байна

-Би Хөвсгөл аймгаас АШУҮИС-д 800 оноотойгоор элсэн суралцаж байгаадаа туйлын их баяртай байна. Элсэлтийн ерөнхий шалтгалтад бэлтгэхэд тийм ч амар байсангүй. Гэхдээ өмнө минь тулгарч байсан саад бэрхшээлийг амжилттай даван туулж, сурахыг хүссэн сургуульдаа элсэж чадлаа. Би есдүгээр ангид байхаасаа л эмч болох хүсэл мөрөөдөлтэй байсан. Тийм ч учраас заавал АШУҮИС-д элсэх юм шүү гэсэн зорилгыг өмнөө тавьж, элсэлтийн ерөнхий шалтгалтдаа бэлтгэсэн. Эмч гэдэг хүн ардынхаа эрүүл мэндийн төлөө мэдлэг чадвар, сэтгэл зүрхээ харамгүй зориулдаг хамгийн сайхан мэргэжил гэж би боддог. Тийм учраас энэ эрхэм мэргэжлийг эзэмшихэд сургууль маань тусална гэдэгт бат итгэлтэй байна.

Анх наймдугаар сарын 21-нд сургуулийнхаа алтан босгоор алхсан. Тэр үед гаднаасаа ч, дотроосоо ч маш тохилог, тав тухтай орчин намайг угтсан. Энэ орчинд илүү ихийг сурч, улам сайн амжилт гаргаж чадна гэсэн итгэл найдвар төрж байлаа. Энэ дашрамд бүх нэгдүгээр дамжааны оюутнуудынхаа өмнөөс биднийг тав тухтай, тохилог орчинд найрсгаар, халуун дотноор хүлээж авсан сургуулийнхаа хамт олонд талархаж буйгаа илэрхийлье. Эмч хүнийг тодотгодог, цэвэр цагаан сэтгэлийн бэлгэдэл болсон хамгийн сайхан хувцас цагаан халад, чагнуурыг хичээлийн шинэ жилийн нээлтийн үеэр хүндтэй хүмүүсээс гардаж авсандаа маш их баяртай байна. Багш нар, сургуулийн удирдлагуудынхаа хүлээлгэж буй итгэл, найдварыг алдахгүй сайн эмч болох болно.

## М.Сэргэлэнбаяр: Эмч хүн бусдад аз жаргал, баяр баяслыг өгдөг

-Би Ховд аймгаас АШУҮИС-д элсэн суралцаж байна. Манай гэр бүлд эмч байхгүй. Эцэг, эх минь миний хүсэл сонирхлыг маш их дэмждэг. Тэр утгаар багын мөрөөдлөө биелүүлэх эхний алхмаа хийж, Элсэлтийн ерөнхий шалгалтдаа 800 оноо авч, мөрөөдлийнхөө сургуульд элсэж чадсандаа туйлын их баяртай байна. Би бусдад туслах дуртай. Хэн нэгэнд туслах үед тэр хүний баяр хөөр, талархал надад маш их урам зориг, аз жаргал өгдөг учраас эмч мэргэжлийг сонгосон. Эмч хүн бусдын эрүүл мэндийн төлөө ур чадвар, мэдлэг чадвараа дайчлан ажиллаж, бусдад аз жаргал, баяр баяслыг хайрлаж байдаг. Би есдүгээр ангиасаа хойш АШУҮИС-д элсэнэ гэсэн зорилгыг өмнөө тавьж, бэлтгэж эхэлсэн. Хичээлийн шинэ жилийн нээлтийн үеэр салбарынхаа эрхэм, хүндтэй хүмүүсээс цагаан халад, чагнуурыг гардан авахад үнэхээр сайхан байсан. Цаашид тэр хүмүүс шиг сайн эмч, мундаг сэхээтэн болох болно.



ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр +23
Шөнө +7

Нөгөөдөр
Өдөр +25
Шөнө +10

**Өдрийн зурхай**

**НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХ МОРЬ ӨДӨР**

**Үс засуулбал:** *Жаргал ирнэ.*

**Наран ургах, шингэх:** *06.19-19.27*



Тухайн өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд зерэг сайн. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, гарагийг тахих, тангараг тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар явaар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал ирнэ.




Ins Tinct

Ах маань гэрт байсан хөх томруулдаг тосоор орой бүр нүүрээ цэвэрлэдэг байсныг сая л мэдлээ. Даанч нүүр нь хавагнаад байсан юм. ха ха ха

# Н.ТҮВШИНБАЯР ДЭЛХИЙН АВАРГЫН МЕДАЛЬТАН БОЛЖ, МОНГОЛЫН БАГ ТҮҮХЭН АМЖИЛТ ҮЗҮҮЛЛЭЭ




Н.БОЛД

Унгарын нийслэл Будапешт хотноо жүдо бөхийн ДАШТ болж өндөрлөлөө. Энэ удаагийн дэлхийн аваргад Монголын баг тамирчид бүтэн багаараа оролцож, нийт зургаан медаль хүртэж, түүхэн амжилт үзүүлсэн юм. Тэмцээний сүүлчийн өдөр +100 кг-д барилдсан Олимпын алт, мөнгөн медальт Н.Түвшинбаяр хүрэл медаль хүртэж, бахдам амжилт үзүүллээ. Манай тамирчин өмнө нь 100 кг-д барилдаж байхдаа дэлхийн авaргаас медаль хүртэж амжаагүй байсан юм. Хоёр удаа тав, нэг удаа долдугаар байрт шалгарч байлаа. Тэгвэл жин өгсч, +100 кг-д зодоглож, дэлхийн үлэмж биет томчуудтай барилдаад дутуугаа гүйцээж, медаль хүртэж чадлаа. Тэр үнэхээр агуу аварга юм байна. Н.Түвшинбаяр аварга торгуулийн тойрог болон медалийн төлөө Гүржийн хоёр бөхийг дараалан ялж, хүрэл дээр буусан. Медаль хүртсэнийхээ дараа тэрбээр "Би өмнө нь дэлхийн авaргаас медаль хүртэж чадаагүй байсан. Харин энэ удаад хүрэл медаль хүртэж чадлаа. Магадгүй хамгийн сүүлчийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээндээ оролцож, медаль хүртэж чадсандаа баяртай байна" хэмээн сэтгэгдлээ илэрхийлсэн билээ.

Ийнхүү Н.Түвшинбаяр Олимпын алт, мөнгөн медаль дээрээ дэлхийн аваргын хүрэл нэмж чадлаа, дутуугаа гүйцээлээ. Мөн Монголын баг тамирчид энэ удаагийн ДАШТ-ээс нэг алт, нэг мөнгө, дөрвөн хүрэл, нийт зургаан медаль хүртэж, түүхэн амжилт үзүүллээ. Өмнө нь 2015 оны дэлхийн аваргаас манай баг тамирчид гурван хүрэл медаль хүртэж байсан нь рекорд амжилт болж байв. Тэгвэл энэ удаад хоёр жилийн өмнөх амжилтыг давуулан биелүүлж, зургаан медаль хүртэж чадлаа. Ингэснээр багийн дүнгээр дэлхийн 126 орноос гуравдугаар байрт шалгарлаа. Японы шигшээ баг долоон алт, дөрвөн мөнгө, нэг хүрэл медальтайгаар багийн дүнгээр тасархай тэргүүллээ. Харин Францын баг хоёр алт, нэг хүрэлтэйгээр хоёрдугаар байрт шалгарсан юм. Медалийн чанараар гэсэн үг. Харин медалийн тоогоор бол манайх Японы араас орсон. Ийм л бахдам амжилтыг манай тамирчид үзүүллээ. Энэ удаагийн дэлхийн аваргад оролцсон тамирчдаас эрэгтэйчүүдийн 66, эмэгтэйчүүдийн +78 кг-д зодоглосон бөхчүүд эхний тойрогтоо ялагдал хүлээснийг эс тооцвол бусад нь дэлхийн бөхчүүдийг айлгасан. Тиймдээ ч дэлхийн томоохон хэвлэлүүд Монголын баг тамирчдыг, тэр дундаа Д.Сумъяа, Н.Түвшинбаяр тэргүүтэй аваргуудыг онцолж байна. Монголын жүдочид яах аргагүй дэлхийд тэргүүлж эхэллээ.

Books "Ном" буланд тавтай морил

# ИХ ГЭРИЙН ЭЗЭГТЭЙ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь №146, 147 дугаарт**

Жеми шөнөжин элдвийг бодож зовж хоноод Ван Дер Мервегийн өгсөн зургийг мартахаар шийдэж, олон хүний санаа зөвлөгөөг эс хайхран Молдер голын дагуу дорно зүг явахаар шийдэв. Жеми миссис Жордантай салах ёс хийгээд аян замдаа орлоо. 3 өдөр, 3 шөнө явсны эцэст тохиромжтой газар олж, тэнд майхнаа босгов. Голын хоёр талаар том том үхэр чулуу лүгхийх агаад Жеми бүдүүн модоор хөшүүрэг хийн том чулууг хөдөлгөн доорхи хайрга чулуунд хүрэхийг хичээнэ.

Үүрийн гэгээнээс үдшийн бүрэнхий хүртэл газар ухаж, алмас байгаагийн шинж бүхий шар шавар юм уу, тийм чулуулаг олохыг оролдож байлаа. Бүтэн долоо хоног болоход ядахдаа жижиг чулуу ч олдсонгүй. Тэгэхээр нь дахиад аян замд орлоо. Нэгэн удаа алсад нарны туяанд хурц тод гэрэлтэн буй мөнгөн байшин шиг юм харагдахад " Миний нүд сохорч байгаа юм болов уу" гэж Жеми бодов. Ойртож очиход бүх байшинг нь мөнгөөр барьсан юм шиг тосгон байв. Гудамжаар нь уранхай ноорхой хувцастай индианууд явж байв. Жеми эргэн гайхан харж явлаа. Мөнгөн байшин шиг харагдсан юм нь лаазалсан махны лаазаар зүйж хийсэн муусайн оромж байжээ. Цаашаа замаа үргэлжлүүлэн нэг цаг яваад эргэж харахад тэр тосгон гялалзан туяаран байв. Энэ нэгэн үзэгдэл Жемийн ой ухаанд мартагдашгүй хадагдан үлджээ.

Одоо Жеми умар зүгийг барин нэгэн голын хөвөөлөн явж, зам зуур алмас байж болмоор газар ухаж үзэж байв. Гар нь царил даахаа болиход нойтон хайрга чулууг элгэгдэж эхэлнэ. Шөнө болохоор үхсэн юм шиг унтдаг байлаа.

Хоёрдах долоо хоногийн сүүлчээрголыгөгсөнПаардепан хүрээний зүг явж байлаа. Голын тохойд хоноглохоор буугаад түүдэг гал дээр мах шарж, цай чанаж аваад идэж уух зуур, хязгааргүй тэнгэрт гялбалзах оддыг ширтэн байв. "Би энд юу хийж яваа хүн бэ? Тэнэг өвчтэй юм шиг ээрэм цөлд ирж, чулуу онгилж, шавар ухаж явна. Гэртээ сууж байсан минь дээр байж. Бямба гариг хүртэл нэг ч алмас олохгүй бол буцах мөрөө хайя" хэмээн Жеми бодлоо.

- Миний үгийг дуулж байна уу? Чөтгөр алгад чамайг...

"Ай тэнгэр минь, Би галзуурч байна" гэж бодлоо. Жеми хий гиюүрэн хурууныхаа салаагаар элс урсгаж суугаад гэнэт нэг том чулуу дайралдхад нь хальт хараад хажуу тийш нь шидэж орхив. Сүүлийн хэдэн долоо хоногт түүний гарт ийм чулуу хэдэн мянгаараа дайралддаг байсан. Ийм чулууг Ван Дер Мерве юу гэж хэлж байлаа? Schlenters гэсэн. Гэтэл саяны чулууны нэг юм нь Жемийн анхаарлыг татаад байлаа. Босож очоод авч үзвэл бусад чулуунаас хамаагүй том болж ирээд этгээд сонин хэлбэртэй ажээ. Жеми тэр чулууг өмдөндөө арчаад анхааралтай үзвэл алмас мөн шиг байлаа. Хэмжээгээр тахианы өндөгний хэрийн том ажээ. " Ай тэнгэр




Жеми зохих ёсоор Клипдрифтэд эргэж ирлээ. Нэг жижиг алмасаа морь тэргээр арилжиж, хамжаа түншийгээ гомдоохгүй, юм сануулахгүй гэж бүх зардлыг нарийн нягт тооцоолсон аж.

минь, Энэ чинь алмас эрдэнэ мөн бол?" гэж дотроо бодоод гэнэт амьсгал нь давхцав. Гар дэнлүү шүүрч аваад газраар тэмтэрч эхлэлээ. 15 минутын дараа дахиад 4 чулуу оллоо. Хэмжээгээр түрүүчийнхээс жижиг ч гэсэн залуу эрийн цээж баяр баясгалангаар бялхлаа. Үүрээр сэрээд солиотой юм шиг малтаж үзэв. Үд болтол дахиад зургаан алмас оллоо. Бүтэн долоо хоног газар малтаж, олсон алмасаа нууцгай газар хадгалж байлаа. Өдөр бүр шинэ, шинэ алмас олж, эрдэнэ баялаг нь хэрхэн аривжиж байгааг хараад аз хийморьтойдоо баярлаж барахгүй байв. Энэ эрдэнэсийн зөвхөн тэн хагас нь Жемигийн өөрийнх нь. Гэхдээ энэ ч гэсэн ухаанд багтамгүй баян болоход бүрэн хангалттай билээ. Жеми долоо хоногийн эцэст уул газрыг зураг дээр тэмдэглэн авч, царил хүрээ тэг зураад үнэлж баршгүй их эрдэнэсээ үүргэвчийн ёроолд хийж, Магердамыг зорилоо.

...Жижиг конторын дээрх хаяг гуншинг уншвал,

"Алмас худалдан авна" гэжээ.

Бөгчим жижиг өрөөнд ороод Жеми гэнэт балмагдан сандрав. Эрэлчдийн алмас эрдэнэ гэж авчирсан чулуу нь жинхэнэ хэрэг дээрээ хэнд ч хэрэггүй чулуу байсан тийм намтар бишгүйдээ сонссон билээ. " Минийх бас тийм чулуу байвал яана? Хэрэв..." гэж бодоод бэмбэгнэв. Контортоо ширээний ард сууж байсан үнэлэгчийг

- Танд юугаар туслах вэ? Гэж асуухад нь Жеми нэгэнтээ санаа алдан

- Ийм юм аа, эрхэм ээ. Та энэ чулууг үзээд өгөхгүй юү? Гэв.

Жеми үүргэвчнээсээ чулуу гарган ширээн дээр тавихад үнэлэгч анхааралтай харж байснаа ширээн дээр байгаа 28 алмасыг нүд бүлтийлгэн ширтэж,

- Хаанаас? Та үүнийг хаанаас олоо вэ? Гэхэд нь

- Хэрэв та үүнийг жинхэнэ алмас эрдэнэ мөн гэж нотолбол дараа нь хэлье гэсэнд үнэлэгчхамгийн том алмасыг авч галт шилээр үзэж байснаа

- Ай тэнгэр, Энэ насандаа ийм том алмас үзээгүй юм байна гэж уулга алдах нь тэр.

Жемийн амьсгаа давхцан, хөөрөн бяарласандаа дороо цовхчин бужиглэхэд бэлэн байлаа.

- Та энэ алмасуудыг хаанаас олоо вэ? Хэмээн үнэлэгч гуйж царайчилсан байдалтай асуув.

- 15 минутын дараа гуанзанд очоорой. Тэгээд танд бүгдийг ярьж өгье гэж Жеми

инээмсэглэн хариуллаа. Жеми алмасаа цуглуулан авч халаасандаа хийгээд гадагш гарч эндээс хоёр байшингийн цаана байдаг бүртгэх контор руу очлоо. Тэнд очоод,

- Би энэ хэсэг газрыг Саломон Ван Дер Мерве, Жеми Макгрегорын нэр дээр бүртгүүлж шав тавихыг хүснэ гэлээ.

Жеми энэ хаалгаар үгээгүй ядуу хүн орж ирсэн бол одоо олон саяар тоологдох хөрөнгө бэлтэй баян хүн болоод гарч ирэв. Жемийг гуанзанд очиход эрдэнэс үнэлэгч тэнд байж байлаа. Жемигийн олз омгийг бүгдэд ярьсан бололтой. Учир нь түүнийг ормогц гуанзанд чив чимээгүй болж, хүн бүхний царайд адилхан нэгийг асуусан байдал илэрлээ. Жеми лангууны дэргэд очоод баарын хүнд хандан

- Би олзоо мялааяа... гээд цугласан олонд хандан,

- Паардспан гэв.

Элис Жордан авгай гал тогооныхоо өрөөнд цай ууж суусанаа Жемийг орж очиход баярын царайгаар инээмсэглэн угтаж,

-Жеми, Энх мэнд эргэж ирсэн чин юутай сайн юм бэ гэж дуу алдаад урагдаж ноорсон хувцас хунар, улаан толбо болсон нүүрийг ажин харж,

- Ажил чинь бүтсэнгүй юү? Бүү гутар. Надтай хамт сууж цай уу, дүү минь. Тэгээд дотор чинь онгойно гэжээ. Жеми нэг ч үг хэлэлгүй халаасандаа гараа хийж, нэг том алмас гаргаж ирээд миссис Жорданы алган дээр тавьж

- Би хэлсэн үгэндээ эзэн болж, үүнийг танд барья гэсэнд авгай тэр чулууг харж, харж нүдэнд нь нулимс мэлтэгнэн

-Үгүй дээ, Жеми минь. Үүгээр би яах билээ. Чи ойлгохгүй байна уу, дүү минь? Энэ чинь хүний занг эвддэг юм... хэмээн аяархан хэлжээ.

Жеми зохих ёсоор Клипдрифтэд эргэж ирлээ. Нэг жижиг алмасаа морь тэргээр арилжиж, хамжаа түншийгээ гомдоохгүй, юм сануулахгүй гэж бүх зардлыг нарийн нягт тооцоолсон аж. Клипдрифт орох зам саадгүй, тааламжтай сайхан байв. Клипдрифтээс гарсан цагаас хойш ямаршуухан аймшигт зовлон үзэж өнгөрүүлснээ санаад "Ядуу, баяны ялгаа нь үүнд байдаг юм байна. Ядуу хүн явган явж байхад баян хүн сүйх тэргээр морилж байдаг гэж боджээ. Жеми морио аяархан ташуурдаж хязгаар хярхаггүй ээрэм талаар давхилаа.

**Үргэлжлэл дараагийн дугаарт**


Реклам, зар сурталчилгааны алба: **99173710**